

Хуучин Гэрээ

Оюутны гарын авлага



Өмнөх үг

Энэхүү цуврал хичээл нь Хуучин Гэрээн дэх сургаалуудад чиглэх боловч Агуу Үнэт Сувд судрын Мосе болон Абрахамын номуудыг багтаадаг. Эдгээр ном нь Тэнгэр дэх зөвлөлөөс эхлэн Аврагчийг төрөхөөс өмнөх хүртэлх үеийн Бурханы хүмүүстэй харьцаж байсан харилцааг илтгэдэг, итгэл, дуулгавартай байдлын хүчирхэг жишээ юм. Мөн Бурханыг умартах, үл дагах болон эсэргүүцэхийн үр дагавруудыг харуулдаг. Энэ номын бошиглолууд нь Аврагчийн төрөлт, цагаатгал, хоёрдахь ирэлт болон мянган жилийн хаанчлалыг гэрчилдэг.

Энэ гарын авлагад долоо хоног бүрийн унших даалгавруудыг тоймлон, тэдгээрт тохирох асуултуудыг бэлтгэж, илүү гүнзгийрүүлэн ойлгоход туслах нэмэлт судрын эшлэлүүд бий. (Судруудын Удирдамж, ХҮГ-ийн Хаан Жеймсийн Библийн зүүвэр тайлбарууд зэрэг тус болохуйц олон санааг багтаасан болно.) Гарын авлага нь дараах зорилгуудаар хэрэгжинэ. Үүнд:

А. Судраас хувиараа суралцах. Даалгавар бүрийн асуултуудаас Хуучин Гэрээний бошиглогчид та нарыг Христтэй илүү ойр болоход чинь хэрхэн тусалж чадахыг харж болно.

Б. Судраас гэр бүлээрээ суралцах. Энэ нь гэр бүлийн үдшийн хичээлүүд болон гэр бүлийн бусад ярилцлагуудад чухал материал юм.

В. Ангийн ярилцлаганд бэлтгэх. Та нар унших нэмэлт материалыг судлах болон тохирох асуултуудыг тунгаан бодсоноор Сайн Мэдээний Сургаалын хичээлдээ бодитой хувь нэмэр оруулах бэлтгэлтэй байх болно.

Сүнсний удирдамжтайгаар судраас суралцсанаар Иовын адил “Гэгэлгэгч амьд гэдгийг болон эцсийн өдөр тэрээр дэлхий дээр байр сууриа эзэлнэ гэдгийг би мэднэ” (Иов 19:25) хэмээн гэрчлэх боломжтой байх болно.

“Миний ажил мөн миний алдар суу”

Моце 1

Дараах судруудыг судал:

А. Моце 1:1–11. Моце Бурханыг харан түүнтэй нүүр тулан ярилцдаг. Моце Эцэгийн Төрсөн Ганц Хүүгийн адилаар Бурханы хүү гэдгээ олж мэддэг.

Б. Моце 1:12–23. Сатан Мосег шалгаан өдөхөд Моце түүнийг хөөн явуулдаг.

В. Моце 1:24–39. Бурхан дахин гарч ирэн, өөрийнхөө ажил болон алдар суугийн тухай заадаг.

- Моце 1:1–7-д тайлбарласан үйл явдлаас Моце Бурханы талаар юу олж мэддэг вэ? Моце өөрийнхөө талаар юу олж мэддэг вэ? Бид түүний

Хүүгийн адилаар бүтээгдсэн Бурханы хүүхдүүд гэдгийг мэдсэнээр бидний амьдрал хэрхэн өөрчлөгдөж чадах вэ?

- Сатаны сорилтуудыг давах эрч хүчийг Моце хэрхэн олж авсан бэ? (Моце 1:18, 20–21 –г үз.) Моце хэрхэн Сатаныг явуулж чадсан бэ? Залбирал нь уруу таталтыг даван туулах хүчийг хэрхэн өгдөг вэ? Энэ хүчийг олж авахын тулд бид өөр юу хийж чадах вэ?
- Бурхан олон дэлхийг бүтээсэн ба хүмүүс нь тоо томшгүй олон боловч Тэрээр биднийг нэгд нэгэнгүй мэд-

дэг гэдгийг Мосед баталж чадсан юм (Моисе 1:35). Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христ чамайг мэддэг мөн хайрладаг болохыг чи яаж мэдэрдэг бэ?

- Яагаад Бурханы ажил болон алдар сууг мэдэх нь бидэнд чухал вэ? Түүний энэхүү гайхамшигт ажилд бид хэрхэн тусалж чадах вэ?

“Чи төрөхөөсөө өмнө сонгогдсон билээ”

Абрахам 3, Моисе 4:1–4

2

Дараах судруудыг судал:

- A. Абрахам 3:11–12, 22–23; Сургаал ба Гэрээ 138:53–57. Абрахам Их Эзэнтэй нүүр тулан ярилцаж мөнх бус байдлын өмнөх амьдралд “нэр төртэй хийгээд агуу суутнууд” олон сүнснүүд мөнх бус байдалд урьдчилан томилогдсоныг мэддэг (Абрахам 3:11–12, 22–23). Ерөнхийлөгч Иосеф Ф.Смит “нэр төртэй хийгээд агуу суутнууд”-ын тухай Аврагч Амилуулалтаасаа өмнө сүнсний дэлхий дээр айлчилсан тухай үзэгдлээс илүү ихийг олж мэддэг (С ба Г 138:53–57).
- B. Абрахам 3:24–28; Моисе 4:1–4. Тэнгэр дэх Зөвлөлөөр Есүс Христийг бидний Аврагч болгосон ба бид Түүнийг дагахыг сонгосныг Абрахам, Моисе нарт үзэгдлээр үзүүшдэг. Мөн Люсифер (Сатан) болон түүнийг дагасан сүнснүүд тэнгэрээс хөөгдсөнийг үзүүлсэн юм.
- Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит сүнсний дэлхийн тухай үзэгдэлдээ

хэнийг харсан бэ? (С ба Г 138:53–г үз.) Эдгээр хүмүүс нь урьдчилсан томилолтоор юу хийхээр томилогдсон бэ? (С ба Г 138:55–56-г үз.)

- Бурхан бошиглогчдыг урьдчилан томилсноос гадна өөрийн хаант улсыг байгуулахад туслуулахаар “өөр бусад сонгогдсон сүнснүүдийг” урьдчилан томилсон юм. Та нар юу хийхээр урьдчилан томилогдсон байж болох бэ? (С ба Г 138:56-г үз.)
- Тэнгэр дэх Зөвлөлд бидний Аврагч болохоор ямар хоёр сүнс саналаа өгсөн бэ? (Абрахам 3:27; Моисе 4:1–2-г үз.) Тэдний саналууд юугаараа ялгаатай байсан бэ? Тэнгэрлэг Эцэг Есүс Христийг яагаад бидний Гэтэлгэгч болгон сонгосон бэ? (Моисе 4:2–3-г үз.)

Нэмэлт унших материал: Исаиа 14:12–15; Илчлэлт 12:7–9; Алма 13:3–5; Сургаал ба Гэрээ 29:36–39; Абрахам 3-ийн үлдсэн шүлгүүд болон Сургаал ба Гэрээ 138.

Бүтээлт

Моисе 1:27–42; 2–3

3

Дараах судруудыг судал:

- A. Моисе 1:27–42. Моисе Бурханы бүтээлүүдийн талаар үзэгдлийг хүлээн авч дэлхийг бүтээсэн тухай тайлбар бичих зарлиг хүлээн авдаг.
- B. Моисе 2:1–25; 3:1–14. Бурхан бол бүхнийг Бүтээгч болохыг Моисе олж мэднэ.

- B. Моисе 2:26–31; 3:7, 15–25. Бурхан эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг өөрийн дүр төрхөөр бүтээснийг Моисе олж мэднэ.
- Бурхан бүтээлтийн зорилгыг юу гэж тайлбарласан бэ? (Моисе 1:39; Абрахам 3:24–25; болон 1 Нифай 17:36-г үз.)

- Бурхны бүтээлүүдээс аль нь чамд онцгой үзэсгэлэнтэй вэ? Өдөр бүр эдгээр бүтээлүүдийн гоо сайхныг анхааралтай ажиглах нь бидэнд ямар үр дүнг өгдөг вэ?

- Эдгээр бүтээлүүд Бурханыг хэрхэн “гэрчилдэг” вэ? (Моисе 6:63; Алма 30:44-г үз.)

Унших нэмэлт материал: Абрахам 4–5, Эхлэл 1–2.

“Миний зөрчлийн улмаас нүд минь нээгдсэн”

4

Моисе 4; 5:1–15; 6:48–62

Дараах судруудыг судал:

- A. Моисе 4; 5:10–11; 6:48–49, 55–56.
Сатан Едений цэцэрлэгт ирэн Еваг мэхлэхийг эрэлхийлнэ. Ева, Адам хоёр сайн ба мууг мэдэх мэдлэгийн модны жимснээс иднэ (4:5–12). Уналтын улмаас Адам, Ева хоёр цэцэрлэгээс хөөгдөнө (4:13–31). Хожим нь Адам, Ева хоёр уналтын адислалуудад талархана (5:10–11). Енох туслах үр нөлөөнүүдийн тухай заадаг (6:48–49, 55–56).
- B. Моисе 5:14–15; 6:50–54, 57–62. Есүс Христийн Цагаатгалын улмаас мөнх бус бие махбодийн үхлээс амилуулалтаар аврагдсан бөгөөд итгэл, наманчлал, баптисм, Сүнсний бэлэг болон зарлигуудыг дуулгавартай дагаснаар сүнснэг үхлээс аврагдаж болно.
- B. Моисе 5:1–9, 12. Адам болон Ева мөнх бус амьдралаа эхэлнэ. Тэд өөрсдийн хүүхдүүддээ сайн мэдээний үнэнийг заадаг (5:1–4, 12). Адам

Төрсөн Ганц Хүүгийн золиослолын адил өргөлүүдийг өргөдөг (5:5–9).

- Адам ба Евад Уналтын үр нөлөөнүүд ямар байсан бэ? Мөн бидэнд ямар байх вэ? (Моисе 4:22–29; 5:10–11; 6:48–49, 55–56; 2 Нифай 2:22–23; 9:6; Эхлэл 3:16–23-г үз.)
- Ихэнх тохиолдолд Бошиглогчид Адам Ева хоёрын уналтын талаар заахдаа Есүс Христийн Цагаатгалын талаар мөн заадаг. (Моисе 5:10–15; 6:48–62; 2 Нифай 9:6–10). Цагаатгал болон уналтын тухай хамт заах нь яагаад чухал вэ?
- Адамын өргөлүүдийн зорилго юу байсан бэ? (Моисе 5:7–9-г үз.) Бидэнд ямар ижил төстэй сануулгууд өгөгдсөн бэ?

Унших нэмэлт материал: Эхлэл 2–3; 1 Коринт 15:20–22; 2 Нифай 2:5–30; 9:3–10; Хиламан 14:15–18; Сургаал ба Гэрээ 19:15–19; 29:34–44; Итгэлийн Тунхаг 1:2; “Fall of Adam” Bible Dictionary, хуудас 670.

“Хэрэв чи сайныг хийх аваас, чи хүлээн авагдах ёстой”

5

Моисе 5–7

Дараах судруудыг судал:

- A. Моисе 5:16–41. Каин Бурханаас илүү Сатанд хайртай бөгөөд Сатаны тушаалыг даган Их Эзэнд өргөл өргөдөг (5:16–19). Их Эзэн Каиний өргөлөөс татгалзсан бөгөөд түүнийг наманчлахыг тушаадаг (5:20–25).

Каин Сатантай гэрээ байгуулан Абелиг алдаг (5:26–33). Их Эзэн Каинийг хараах ба Каин Их Эзэний дэргэдээс хөөгддөг (5:34–41).

- B. Моисе 6:26–63. Адамын дөрөв дэх ач хүү Енох наманчлалыг номлохоор Их Эзэнээр дуудагддаг (6:26–36).

Енох Их Эзэний тушаалыг дуулгавартайгаар дагадаг (6:37–63).

В. Моце 7:13, 17–21, 23–47, 68–69.

Енохын итгэл нь агуу бөгөөд уулс нүүн, голын ус голдрилоосоо эргэж, бүх үндэстнүүд эмээдэг (7:13, 17). Их Эзэн, Енох хоёр дэлхийн хүмүүсийн ёс бус явдалд харамсан уйлав (7:23–47). Енох хотын хүмүүс Их Эзэнтэй нэг зүрх сэтгэл, нэг оюунтай бөгөөд хот бүхэлдээ тэнгэрт аваачигддаг. (7:18–21, 68–69).

• Их Эзэн Абел хаана байгааг асуухад Каин хэрхэн хариулсан бэ? (Моце

5:34-г үз.) Өөрсдийн ах дүүгийн хамгаалагч байх гэдэг нь юу гэсэн үг вэ? (1 Иохан 3:11, 17–18.)

• Их Эзэн яагаад Енох болон түүний хүмүүсийг Сион гэж дуудсан бэ? (Моце 7:18.) “Нэг зүрх сэтгэл, нэг оюунтай” байна гэдэг нь ямар утгатай вэ? Гэр бүлдээ болон сүмд Их Эзэнтэй нэг зүрх сэтгэл, нэг оюунтай болохын тулд бид юу хийж чадах вэ?

Унших нэмэлт материал: Моце 5:42–55; 6:10–23; 7:14–16, 59–64; 2 Нифай 2:25–27; Эхлэл 4:1–16.

“Ноа гэр бүлээ аврахын төлөө хөвөгч авдар бэлтгэдэг”

Моце 8:19–30; Эхлэл 6–9; 11:1–9

6

Дараах судруудыг судал:

А. Моце 8:19–30; Эхлэл 6:5–22; 7:1–10.

Ноа сайн мэдээг номлосон боловч хүмүүс сонсдоггүй (Моце 8:19–25). Хүмүүсийн ёс бус явдлаас болоод Их Эзэн бүх махан бодиудыг дэлхийгээ устгана гэдгээ мэдэгддэг (Моце 8:26–30; Эхлэл 6:5–13). Их Эзэн Ноад хөвөгч авдар барихыг тушааж гэр бүл болон амьд биет болгоноос хоёрыг авч хөвөгч авдарт орохыг зарлиг болгосон (Эхлэл 6:14–22; 7:1–10).

Б. Эхлэл 7:11–24; 8; 9:8–17. Дөчин өдөр, дөчин шөнө бороо орсон (7:11–12). Хөвөгч авдарт байсан бүх хүмүүс, амьтад амьд үлдэв (7:13–24). Ус татарсаны дараа Ноа болон түүний гэр бүлийнхэн, амьтад хөвөгч авдарнаас гарч, Ноа Их Эзэнд тахил өргөдөг (8:1–22). Их Эзэн Ноатай хийсэн гэрээнийхээ тэмдэг болгож солонго татав (9:8–17).

В. Эхлэл 11:1–9. Энэ үерээс хойш хэдэн үеийн дараа хүмүүс тэнгэрт хүрэх цамхаг барихыг оролддог.

Их Эзэн тэдний хэлийг будилуулан дэлхийн бүх хэсэгт тараав.

• Их Эзэн Ноаг сайн мэдээг номлохыг дуудахад дэлхий ямархуу байсан бэ? (Моце 8:20–22-г үз.) Ноагийн үеийн болон өнөөгийн хүмүүсийн хооронд ямар ижил төстэй зүйлсийг та нар харж байна?

• Ноагийн үед амьдарч байсан хүмүүс устгалаас хэрхэн зайлсхийж болох байсан бэ? (Моце 8:23–24-г үз.) Бошиглогчдыг сонсож дагах нь сүнсний болон бие махбодын устгалаас зайлсхийхэд бидэнд хэрхэн туслах вэ?

• Ноа яагаад хөвөгч авдар хийсэн бэ? (Еврей 11:7-г үз.) Өнөөдөр ямар “хөвөгч авдрууд” бидний эргэн тойронд байгаа хилэнцүүдээс биднийг аварч чадах вэ? (Энэ асуултын хариултыг Залуучуудын Бат Бэх Байдлын Төлөө товхимлоос харна уу [36550].) Бид бусдад хэрхэн эдгээр “хөвөгч авдруудад” орогноход нь тусалж чадах вэ?

Унших нэмэлт материал: Еврей 11:7; Моце 7:32–36.

Абрахамын Гэрээ

Абрахам 1:1–4; 2:1–11; Эхлэл 12:1–8; 17:1–9

7

Абрахам 1:1–4; 2:1–11; Эхлэл 12:1–8; 17:1–9-ийг суралц. Эдгээр ишлэлүүдэд Абрахам Бурханы адислалыг авахаар зөв зохистой, шударга байхыг хичээдэг. Бурхан Абрахамтай гэрээ байгуулан Абрахам тоолж баршгүй их үр удамтай болж амлалтын нутаг болон санваарын адислалууд, сайн мэдээг хүлээн авах болно хэмээн амласан билээ.

Сүмийн бүх гишүүд Абрахамын үр удам учраас түүний гэрээний үүрэг амлалтууд, адислалуудын залгамжлагчид юм. Эдгээр гайхамшигт адислалуудыг бид сайн мэдээний гэрээг дагаснаар хүлээн авах болно. Бидний

хийсэн эхний гэрээ бол баптисм юм. Дараа нь бид Абрахамын гэрээг бүхлээр нь ариун сүмд хүлээн авдаг.

- Абрахамын гэрээний хэсэг болгож Их Эзэн Абрахамад ямар адислалуудыг амласан бэ? (Абрахам 2:6–11; Эхлэл 12:1–8; 17:1–9-г үз.)
- Абрахамын гэрээний залгамжлагчид болсноор бидний хүлээх үүрэг хариуцлагууд юу вэ? (Абрахам 2:9, 11; Эхлэл 18:19-г үз.)

Унших нэмэлт материал: Сургаал ба Гэрээ 132:19–24, 29–32; Эхлэл 15; “Abraham Covenant of,” Bible Dictionary, page 602.

Ёс бус дэлхийд зөв шударга амьдрах нь

Эхлэл 13–14; 18–19

8

Дараах судруудыг судал:

- А. Эхлэл 13. Египетэд хэсэг хугацаанд амьдарсны дараа Абрахам, түүний гэр бүлийнхэн Канаанд буцан ирэв. Абрахам Ибронд суурьшин, түүний зээ Лот Содомын ойролцоо суурьшив.
- Б. Эхлэл 14:1–2, 8–24. Лот олзлогдох ба Абрахам түүнийг аварна (14:1–2, 8–16). Абрахам Мелкизедект аравны нэгийг төлөх бөгөөд Содомын хааны дайны олзыг хүлээн авахаас татгалздаг (14:17–24).
- В. Эхлэл 18:16–33; 19:1–29. Хүмүүсийн ёс бус явдлаас болоод Их Эзэн Содом болон Гоморраг сүйтгэнэ хэмээн хэлдэг (18:16–22). Хэрэв Абрахам зөв шударга хүмүүсийг олох юм бол эдгээр хотуудыг өршөөхийг Их Эзэнээс гуйдаг (18:23–33). Лот болон түүний гэр

бүлийнхэнд Содомоос нүүхийг зарлиг болгодог (19:1–23). Их Эзэн Содом болон Гоморраг устгадаг (19:24–29).

- Лот эхлээд “талын хотуудын дунд” Содомын гадна амьдарч байсан ч “майхнаа Содомын ойролцоо босгожээ” (Эхлэл 13:12). Дараа нь тэрээр Содом хотод амьдрал (Эхлэл 14:12). Бид Содомын зүгт майхнаа босгохтой адилаар сүнслэг байдлаар юу хийж болох бэ?
- Их Эзэн Содом ба Гоморраг сүйтгэхийг мэдээд Абрахам юу хүссэн бэ? (Эхлэл 18:23–32-г үз.) Хэрэв хотуудаас зөв шударга хүмүүс олох юм бол Их Эзэн өршөөхийг мэдсэнээр бид юу мэдэж болох вэ?

Унших нэмэлт материал: Эхлэл 12; Иосеф Смитийн орчуулга, Эхлэл 14:25–40; 19:9–15.

Дараах судруудыг судал:

- A. Абрахам 1:1, 5–20. Залуу хөвгүүн Абрахамыг Фараогийн хуурамч пристүүд хавчин мөрдөж байв. Тэд түүгээр золиослол хийхийг завдсан боловч Иехова түүнийг аварна.
- B. Эхлэл 15–17; 21. Амьдралынх нь хожмын өдрүүдэд Абрахамд үр удам амлагдсан (15:1–6). Сараи Хагарыг Абрахамд эхнэр болгон өгдөг: Хагар Ишмаелийг төрүүлдэг (16:1–16). Бурхан ахин Абрахамтай гэрээнийхээ талаар ярьдаг ба Абрахам олон үндэстнүүдийн эцэг болно гэдгийг амладаг (17:1–14). Исаакийн төрөлт тунхаглагдсанаар түүгээр дамжуулан гэрээ үргэлжлэх болно (17:16–22). Сараи Исаакийг төрүүлдэг (21:1–12).
- B. Эхлэл 22. Бурхан Абрахамд Исаакаар өргөл өргөхийг зарлиг болгодог (22:1–2). Абрахам Исаакаар золиослол хийхээр бэлтгэдэг, гэвч Бурхан оронд нь эр хониор золиослол хийлгэхээр өгдөг (22:3–19).

Тэмдэглэл: Эхлэл 17. Их Эзэн Абрамын нэрийг Абрахам, Сараигийн нэрийг Сара хэмээн сольдог (5, 15 шүлгүүдийг үз). Абрахам ба Сара хэмээх нэрүүд энэ бүлгийн турш хэрэглэгдэх болно.

- Абрахам Исаакийг золиосол гэсэн Бурханы зарлигт яаж хариулсан бэ? (Эхлэл 22:2–3 –г үз.) Энэ байдалд Исаак хэрхэн хандсан бэ? (Эхлэл 22:3–10-г үз.) Итгэл болон дуулгавартай байдлын талаар Абрахам, Исаак нараас бид юу суралцаж чадах вэ? (Еврей 11:17–19; Иаков 2:21–23-г үз.)
- Абрахамын Исаакийг золиослоход бэлэн байсан нь Тэнгэрлэг Эцэг өөрийн Төрсөн Ганц Хүүгээ золиослоход бэлэн байсантай адил юм (Иаков 4:5; Эхлэл 22:8, 13). Абрахамын ямар жишээ нь Тэнгэрлэг Эцэгт тохиолдсон явдалтай ижил төстэй байна вэ? Ялгаатай зүйл нь юу вэ?

Унших нэмэлт материал: Еврей 11:8–19; Иаков 2:21–23; Иаков 4:5; Сургаал ба Гэрээ 132:34–36.

Өв залгамжлах эрхийн адислал; Гэрээн дэх гэрлэлт

10

Эхлэл 24–29

Дараах судруудыг судал:

- A. Эхлэл 24. Исаакд зөв зохистой эхнэр сонгохдоо Абрахам гэрээний дагуу гэрлэлтийн чухлыг онцолдог.
- B. Эхлэл 25:20–34. Ребека төрөөгүй байгаа ихэр хөвгүүдийнхээ талаар илчлэлт авдаг (25:22–23). Хөвгүүдийг том болоход Есав өөрийн залгамжлах эрхийн адислалыг Иаковд худалддаг (25:29–34).
- B. Эхлэл 26–29. Исаак болон түүний үр удам Абрахамын гэрээний адис-

лалуудаар амлагдав (26:1–5). Есав гэрээнээс гадуур гэрлэдэг (26:34–35). Исаак Иаковыг хүмүүс болон үндэстнүүдийн удирдагч болгохоор адисалдаг (27:1–46). Исаак Иаковд Абрахамын адислалуудыг тунхаглан, түүнийг зөв зохистой эхнэрийг олуулахаар явуулав (28:1–10). Иаков Леа болон Рахелтай гэрээний дагуу гэрлэдэг (29:1–30).

- Мөнхийн үнэ цэнэтэй зүйлс сонгохын оронд түр зуурын баяр цэнгэл

авчрах зүйлс сонгодгоороо бид хэрхэн Есавтай төстэй алдаа гаргадаг вэ?

- Бид Иаковын гэрээний дагуу гэрлэх чармайлтаас юу суралцаж болох вэ? (Эхлэл 28:1-5; 29:1-28-г үз.)

- Хүүхэд, залуус ариун сүмд гэрлэхийн тулд юуг бэлтгэх ёстой вэ? Хоёр хүн ариун сүмд гэрлэснийхээ дараа үнэхээр мөнхийн гэрлэлттэй байхын тулд юу хийх ёстой вэ?

“Би яаж ийм их муухай хэрэг үйлдэх билээ?”

11

Эхлэл 34; 37-39

Дараах судруудыг судал:

- A. Эхлэл 37. Иаковын арван нэгдэх хүү Иосефыг ах нар нь үзэн яддаг бөгөөд түүнийг боол болгон худалддаг.
- B. Эхлэл 39. Иосеф боол байх хугацаандаа өсөж дэвждэг, гэвч садар самуун явдалд гүтгэгдэн шоронд ордог (39:1-20). Шоронгийн хуяг Иосефт бусад хоригдлыг хариуцуулав (39:21-23).
- V. Эхлэл 34:1-12; 35:22; 38:1-30. Садар самуун явдлын нүгэл нь Иаковын гэр бүлийнхэнд сөрөг үр нөлөө авчирдаг (34:1-12; 35:22; 38:1-30).

Иаковын эхнэр арван хоёр хүү төрүүлэх ба эдгээр нь Израилын арван хоёр угсааг эхлүүлдэг (Их Эзэн Иаковын нэрийг Израил хэмээн сольдог; Эхлэл

32:28-г үз). Иаковын арван нэг дэх хүү Иосеф; Иаков Леа хоёрын том хүү Реубен зөв зохисгүй байдлаас болон залгамжлах эрхийн адислалаа алдахад, Иаков болон Рахел хоёрын том хүү Иосеф залгамжлах эрхийг авдаг (Шастирын Дээд 5:1-2).

- Потифарын эхнэр Иосефыг уруу татахад тэрээр юу хийсэн бэ? (Эхлэл 39:11-12-г үз.) Биднийг уруу татахад бид Иосефын жишээг хэрхэн дагаж чадах вэ?
- Муу тохиолдлууд болон хэцүү нөхцөл байдалд ороход сайн болгох талаар Иосефоос бид юу сурч болох вэ? (Эхлэл 39:20-23; Ром 8:28-г үз.)

Унших нэмэлт материал: Эхлэл 34:13-31.

“Миний зүтгэж хөдөлмөрлөсөн газраас намайг агуу үр бүтээлтэй болгосон”

12

Эхлэл 40-45

Дараах судруудыг судал:

- A. Эхлэл 40-41. Иосеф шоронд байхдаа Фараоны үйлчлэгчдийн зүүдийг үнэн тайлдаг. Тэр Фараоны эрдэнэ шиш болон үхрийн талаарх зүүдийг тайлдаг. Иосеф Фараоны дараагийн удирдагчаар томилогдон бүх Египетийг захиран, хүмүүсээ өлсгөлөнд бэлтгэдэг.
- B. Эхлэл 42-45. Иаков хөвгүүдээ Египет уруу хоёр удаа тариа худалдан авахуулахаар явуулдаг.

Иосеф ах нартаа өөрийгөө таниулан тэднийг уучилснаар бүгдээрээ баярладаг.

- Иосефын ах нар түүнд муу зүйл хийсэн шиг хэн нэгэн бидэнд муу зүйл хийвэл дэлхий биднийг яах ёстой гэдэг вэ? Их Эзэн биднийг яах ёстой гэдэг вэ? (С ба Г 64:8-11-г үз.) Чамд муу хандсан хүмүүстэй эвсэг байснаар чи яаж адислагдсан бэ? Бид хэрхэн илүү амархан уучилж чаддаг болох вэ?

- Иосефын хувьд Египетэд шоронд хоригдож байсан нь зовлон зүдгүүр түүний гэр бүл болон, бүх Египетийн хувьд адислал болсон бэ? (Эхлэл 45:4-8-г үз.) Та нарын

хувьд эхлээд муу байсан тохиолдлуудаас ямар үйл явдлууд дараа нь адислал болсон бэ?

Унших нэмэлт материал: 2 Нифай 2:2; Сургаал ба Гэрээ 64:8-11; 122:5-9.

Боолчлол, Дээгүүр өнгөрөх баяр ба Египетээс Гарсан нь

13

Египетээс Гарсан нь 1-3; 5-6; 11-14

Дараах судруудыг судал:

A. Египетээс Гарсан нь 1-3. Египетчүүд израилчуудыг боол болгов (1:1-14). Израилчуудаас төрсөн хөвгүүдийг бүгдийг алахыг Фараон тушаал болгов (1:15-22). Мосе төрж, Фараоны охин түүнийг өсгөв (2:1-10). Их Эзэн Мосед шатаж байгаа бутанд үзэгдэн Израилыг боолчлолоос авруулахаар дуудав (3:1-22).

B. Египетээс Гарсан нь 5-6. Мосе ба Аарон нар Фараоноос израилчуудыг суллахыг хүсдэг, гэвч Фараон үүнийг эсэргүүцэн илүү хүнд дарамтыг хүмүүст үүрүүлдэг (5:1-23). Их Эзэн Абрахамтай хийсэн гэрээгээ биелүүлэхээр амладаг (6:1-8).

V. Египетээс Гарсан нь 11-13. Их Эзэн Египет уруу олон удаа өвчин тахал илгээсний дараа дахин нэг тахал илгээж, гэр бүлд төрсөн эхний хүүхэд болгон үхэх болгов (11:1-10). Их Эзэн Мосег Дээгүүр Өнгөрөх баярт бэлтгэхэд зааварладаг ба ингэснээр Израилчууд тахлаас хамгаалагдах болно (12:1-20). Египетийн эхний төрсөн хүүхдүүд үхэцгээв (12:29-30). Фараон Мосег өөрийн хүмүүсээ аваад Египетээс явахыг хүсдэг, Израилчууд явав (12:31-42). Мосе Израилын хүүхдүүдэд Исгээгүй Талхны Баярыг тэднийг сулласны билэг тэмдэг болгон үргэлжлүүлэн тэмдэглэхийг захидаг (13:1-16). Их Эзэн өдөр нь

үүлэн баганаар, шөнө нь галан баганаар Израилчуудын нүүдлийн өмнө гэрэлтүүлж явдаг (13:17-22).

G. Египетээс Гарсан нь 14. Фараон болон түүний цэргүүд Израилчуудын араас мөрдөн хөөдөг (14:1-9). Хүмүүс айн түгшиж, Мосе Их Эзэнээс тусламж гуйв (14:10-18). Израилчууд Улаан Тэнгисийг хуурай газраар гатладаг: Фараоны хүмүүс тэднийг хөөж байгаад живэв (14:19-31).

- Сүүлчийн оройн зоогон дээр Аврагч Дээгүүр Өнгөрөх баярыг ариун ёслолоор орлуулав (Матай 26:19, 26-28). Дээгүүр Өнгөрөх баяр болон ариун ёслол хоёрын хооронд ямар ижил төстэй зүйлүүд байдаг вэ? (Египетээс Гарсан нь 12:14; 13:9-10; С ба Г 20:75-79-г үз.)

- Фараоны цэргүүдийг хараад Израилын хүүхдүүдийн итгэл сулрахад Мосе тэдэнд юу гэж хэлсэн бэ? (Египетээс Гарсан нь 14:13-14-г үз.) Айдас түгшүүргэй үед ч биднийг хүчтэй байлгаж чадах итгэлийг бид хэрхэн хөгжүүлэх вэ?

- Их Эзэн Египетийн цэргүүдийг устгаж, Израилын хүүхдүүдийг хэрхэн аварсан бэ? (Египетээс Гарсан нь 14:21-31-ийг үз.) Хүнд хэцүү үед энэ түүх бидэнд хэрхэн тусалж чадах вэ?

Унших нэмэлт материал: Египетээс Гарсан нь 4; 7-10; 15.

Египетээс Гарсан нь 15–20; 32–34

Дараах судруудыг судал:

- A. Египетээс Гарсан нь 15:22–27;
16:1–31; 17:1–7. Израилын хүүхдүүд өлсөж цангасан учраас гомдоллож эхлэв. Их Эзэн тэдэнд ус, манна ба бөднө шувууг өгөв.
- B. Египетээс Гарсан нь 17:8–13;
18:13–26. Амалек Израилтай байлдав. Мосег гараа өргөхөд Израил ялж, харин гар нь цуцан буулгахад Амалек ялж байв. Аарон, Хур нар Мосегийн гарыг өргөж ингэснээр Израил тулаанд ялав (17:8–13). Мосе шүүгчдийг сонгон тэдэнд эрх мэдлийг өгөв (18:13–26).
- B. Египетээс Гарсан нь 19–20. Их Эзэн Мосегэй Синаи уулан дээр уулзан Израилд арван хуулийг өгөв.
- G. Египетээс Гарсан нь 32–34. Мосе Их Эзэнээс заавруудыг багтаасан чулуун хавтангуудыг авсан боловч хүмүүс алтан тугалыг тахин шүтэж байгааг хараад хавтангуудыг хагалав (31:18; 32:1–24). Их Эзэн Мелкизедек Санваарын ёслолуудыг Израилаас аван Дэд Хууль болох Мосегийн хуулийг өгөв (Иосеф Смитийн орчуулга, Египетээс Гарсан нь 34:1–2). Мосе шинэ чулуун хавтангуудыг засаж янзалсан боловч шинэ хавтангууд нь “ариун санваартнуудын мөнхийн гэрээний үгнүүдийг” багтаадаггүй (Египетээс Гарсан нь 34:1–5; Иосеф Смитийн орчуулга, Дэд Хууль 10:2). Хүмүүс

Мосегийн хуулийг дуулгавартай дагахаар гэрээ хийв (34:10–35).

- Манна нь Христийг хэрхэн төлөөлж байна вэ? (Иохан 6:35-г үз.) Христийн амьд талх нь маннагаас юугаараа ялгаатай вэ? (Иохан 6:48–51-г үз.) Бид хэрхэн Христийн амьд талхнаас өдөр тутамд хүртэж чадах вэ?
- Хэрэв тэд дуулгавартай дагавал Их Эзэн Израилын хүүхдүүдэд юуг амласан вэ? (Египетээс Гарсан нь 19:3–6-г үз.) Өнөөдөр бид эдгээр амлалтуудыг хэрхэн хэрэгжүүлдэг вэ?
- Их Эзэн яагаад Мосегийн хуулийг Израилын хүүхдүүдэд өгсөн бэ? (Галат 3:23–24; Мосе 13:29; Алма 25:15–16; С ба Г 84:19–27-г үз.) Энэ хууль нь Израилыг ариун болгож тэднийг Христэд ирэхэд нь яаж туслах вэ? (Мосе 13:30; Алма 34:14–15-г үз.)
- Мосегийн хууль хэзээ биелэгдсэн бэ? (3 Нифай 15:4–10-г үз.) Амьтнаар золиослол хийх нь Мосегийн хуулийн чухал хэсэг байсан боловч өнөө үед Их Эзэн үүнийг шаарддаггүй бөгөөд оронд нь биднийг ямар золиослол хийхийг хүсдэг вэ? (3 Нифай 9:19–22.) Харууссан зүрх, гэмшсэн сэтгэлийн өргөл өргөх гэдэг нь юу гэсэн үг вэ?

Унших нэмэлт материал: Дуулал 78; 1 Коринт 10:1–11; Сургаал ба Гэрээ 84:19–27.

“Бурханд найдан амьдар”

Тооллого 11–14; 21:1–9

Дараах судруудыг судал:

- A. Тооллого 11. Израилчууд маннагийн талаар гомдол гарган мах идэхийг хүсэв (11:1–9). Их Эзэний

зааврын дагуу Мосе ахмадуудаас далан хүнийг өөртөө туслуулахаар цуглуулдаг (11:10–17, 24–30). Их Эзэн Израилчуудын мах идэх хүс-

- лийг нь хариулан тэдэнд их хэмжээний бөднө шувуу илгээх ба тэдний шунаг сэтгэл, даврамгай зангаас болон тэднийг тахлаар цохив (11:18–23, 31–35).
- В. Тооллого 12. Мириам ба Аарон нар Мосегийн эсрэг яриа гаргав (12:1–3). Их Эзэн бувтнасных нь төлөө Мириам ба Аароныг шийтгэн цээрлүүлэв (12:4–16).
- В. Тооллого 13–14. Мосе арван хоёр эрчүүдийг Канааны газрыг тандуулахаар илгээв (13:1–20). Тэд газрын баялагийн талаар тааламжтай мэдээтэй эргэж ирэх боловч оршин суугчдаас нь айн Египет уруу буцахыг хүснэ (13:21–14:10). Их Эзэн Мосед бүх насанд хүрсэн удам угсаа үхэж үрэгдэн зөвхөн Иошуа, Калеб хоёр үлдэж, итгэлгүй гомдоллосон Израилчуудыг цөлд дөчин жил тэнүүлэх болно гэлээ (14:11–39).
- Г. Тооллого 21:1–9. Тэдний эсрэг боссон Канаанчуудыг Израилчууд уст-

гав (21:1–3). Их Эзэн Израилчуудын тасралтгүй гомдлын шийтгэл болгож галт могойг илгээв (21:4–6). Мосе хүрэл могой хийж шургаагны оройд байрлуулан, могойд хатууулж үхсэн хүмүүс үүнийг хараад амьдрах болно хэмээн хэлж байв (21:7–9).

- Израилчууд яагаад маннагийн талаар гомдол гаргасан бэ? (Тооллого 11:4–6-г үз.) Өөрт байгаагаас илүүг хүсэх нь ямар аюултай вэ?
- Израилын хүүхдүүд амьдрахын тулд зэс могойг харах хэрэгтэй байв, бид мөнх амьдралыг авахын тулд Есүс Христийг харах хэрэгтэй (Алма 37:46–47; Хиламан 8:15). Есүс Христийг харна гэдэг нь юу гэсэн үг вэ?

Унших нэмэлт материал: Иохан 3:14–16; 1 Нифай 17:41; Алма 33:18–22; 37:46–47; Хиламан 8:13–15.

“Их Эзэний тушаалтай зөрчилдөх ямар ч зүйлийг би хийж чадахгүй”

Тооллого 22–24; 31:1–16

Дараах судруудыг судал:

- А. Тооллого 22:1–21. Моабийн хаан Балак Израилчуудыг хараад ихэд айв. Тэрээр хэрэв Балаам Моабд ирэн Израилчуудыг зүхвэл шан хөлс өгөхөөр болов. Бурхан түүнд эсэргүүцэхийг тушааж, Балаам дуулгавартай дагана (22:1–14). Хэрэв Балаам Моабд ирэн Израилыг зүхвэл Балак түүнд илүү их шан хөлс, нэр хүндийг өгөхөөр амлав. Бурхан Балаамд тэдэнтэй явахыг зөвшөөрдөг ч, зөвхөн Бурхан түүнд өгсөн үгнүүдийг ярих ёстой гэв (22:15–21). Балаам явахаар шийдэв.
- В. Тооллого 22:22–35. Бурхан Моабруу яван Балакаас шагнал хүсэж байгаад нь Балаамд ууртай байв. Явах замдаа тэр илжигтэйгээ болон тэн-

гэр элчтэй ярилцан, Бурханыг уурлуулах нь ямар аюултай болохыг мэдэв.

- В. Тооллого 22:36–24:25. Балак Балаамаас Израилыг гурван удаа зүхэхийг хүссэнч Балаам Бурханыг дуулгавартай даган харин тухай бүрд нь Израилыг адисалж байв (22:36–24:9). Дараа нь Балак Моабыг болон Есүс Христийн бошиглоуудыг зүхдэг (24:10–25).
- Г. Тооллого 31:1–16. Израилчууд мидиануудыг устган Балаамыг алав. Балаам Израилчуудаар нүгэл хийлгэхээр зөвлөдгийг Мосе тайлбарладаг. (Балаамын зөвлөгөөний хор уршгийн талаар Тооллого 25:1–3-д өгүүлдэг. Балаам Израилыг шууд зүхэхгүй байсан ч тэрээр Балакаас

шагнал авахыг маш их хүсэж байсан нь илт бөгөөд тэр Израилыг нүгэл хийхийг ятган Бурханы хамгааллыг алдахад хүргэлэг.)

- Моабд очиж Израилыг зүхвэл оронд нь шан харамж амласан хүсэлтэнд Балаам ямар хариу өгсөн бэ? (Тооллого 22:5–14-г үз.) Бурханд дуулгаваргүй байсны төлөө шагналууд гэж болох юуг бидэнд санал болгодог вэ?
- Моаб орох замдаа Балаам гурван удаа илжгээ урагш явуулахаар хүчилдэг (Тооллого 22:22–30).

Энэ нь ямар замаар Балаам Их Эзэн хоёрын харилцааг илэрхийлж байна вэ? Үүнтэй ижил Бурханы хүсэл болон удирдагчид, эцэг эхийнхээ зөв шударга зөвлөгөөнүүдийг дагахын оронд өөрсдийн хүссэнээ хийхийг оролддог ямар орчин үеийн хувь хүн болон бүлгүүд байдаг вэ?

- Шинэ Гэрээний гурван бичээч Балаамаас эш татсан байдаг (2 Петр 2:15–16; Иуда 1:11; Илчлэлт 2:14). Түүний талаарх тэдний сэтгэгдэл ямар байсан бэ? Бид Балаамын түүхээс юу сурацгааж чадах вэ?

“Мартахаас болгоомжил”

Дэд Хууль 6; 8; 11; 32

17

Дараах судруудыг судал:

- A. Дэд Хууль 6:1–9; 11:18–21. Мосе израилчуудад гэрээнүүдээ санахад нь туслах заавар өгдөг. Тэр эцэг эхчүүдэд хүүхдүүдээ түүний үгийг заахыг зөвлөдөг.
- Б. Дэд Хууль 6:10–12; 8:1–20. Мосе израилчуудад ирсэн Бурханы адислалуудыг нь сануулдаг. Хэрэв Бурханы зарлигуудыг зөрчвөл тэд шийтгэгдэх бөгөөд Түүнийг сана гэдгийг анхааруулдаг.
- В. Дэд Хууль 32:1–4, 15–18, 30–40, 45–47. Мосе Израилчуудад тэдний авралын Хадыг анхаарах хэрэгтэйг зөвлөдөг (Есүс Христ).

Зэлүүд талд дөчин жил Израилчуудыг сорин, цээрлүүлж заасны дараа Их Эзэн тэднийг амлалтын газарт очиход бэлэн гэдгийг хэлдэг. Гэвч тэдэнд зарим чухал заавруудыг өгдөг. Мосе эдгээр заавруудыг дэд хуулинд тэмдэглэснээр гурван номлол болгон түгээдэг.

- Яагаад Мосе хүмүүст судрын багцыг нүд, гарын хооронд ба гэрийн хаяг, хаалган дээр байрлуулахыг

хэлсэн гэж та нар бодож байна? Ийм байнгын сануулга бидний үйлдлүүдэд хэрхэн нөлөөлөх вэ? Их Эзэн, Түүний үгс болон Түүнтэй хийсэн гэрээнүүдийг бидэнд сануулахын тулд бид гэртээ юу хийж чадах вэ? Ханан дахь зурагнууд, бидний уншдаг номнууд болон үздэг кино, зурагтын үзвэрүүд бидэнд Их Эзэнийг сануулдаг уу? Эсвэл эдгээр нь дэлхийн тэмүүлүүдийг санал болгодог уу?

- Дэд Хууль 6:10–12 болон 8:1–20 дэх Мосегийн гол захиас юу вэ? Их Эзэнийг мартагч гэдэг нь ямар утгатай вэ? (Дэд Хууль 8:11-г үз.) Түүнийг мартагчын үр дагавар нь юу вэ? (Дэд Хууль 8:19-г үз.)
- Дэд Хууль 32:3-4-т яригддаг Хад нь хэн бэ? (Есүс Христ.) Есүс Христийг яагаад зарим тохиолдолд Хад гэж дууддаг вэ? (Хиламан 5:12-г үз.) Хадан дээр барих гэдэг нь юу гэсэн утгатай вэ? (Дэд Хууль 32:46–47; Матай 7:24–27; С ба Г 50:44-г үз.)

Унших нэмэлт материал: Дэд Хууль 4; 7:1–4; 13:1–8; 34.

“Тууштай бөгөөд зоригтой бай”

Иошуа 1–6; 23–24

18

Дараах судруудыг судал:

- A. Иошуа 1. Их Эзэн Мосег залгамжлуулахаар Иошуаг дуудав. Иошуа израилчуудыг Их Эзэний амласан газрыг эзэмшихэд бэлтгэв.
- Б. Иошуа 3–4; 6. Израилчууд Иордан голыг хуурайгаар гатлан ингэж гатласныхаа дурсамж болгон 12 чулуут өрөв. Израилчуудын итгэлээр Иерихо устгагдав.
- В. Иошуа 23; 24:14–31. Иошуа болон түүний хүмүүс Их Эзэнд үйлчлэхээр гэрээ байгуулав.

Израилчуудын бүх удмын хувьд Мосе бол цорын ганц удирдагч байв. Гэвч тэдний зэлүүд талын түр хугацааны аялалын төгсгөлд тэднийг томоохон

сорилттой тулгарах үед Их Эзэн түүнийг авав. Израилтай хийсэн амлалтынхаа дагуу Их Эзэн шинэ удирдагч сонгосон нь Иошуа байв.

- Иошуаг “амжилттай” байлгахын тулд Их Эзэн юу хийхийг сануулсан бэ? (Иошуа 1:8 –г үз) Иошуа дуудлагаа амжилттай хийхэд судраас сурацхал нь яагаад чухал байсан бэ? Судраас тогтмол судлах нь та нарт ямар ач холбогдолтой вэ?
- Амьдралынхаа төгсгөлд Иошуа ямар чухал сургамж өгсөн бэ? (Иошуа 24:14–15-г үз.) Өнөөдрийг Их Эзэнд үйлчлэхээр сонгох нь яагаад чухал вэ? Бид түүнд үйлчлэхээр сонгогдсон гэдгээ хэрхэн харуулах вэ?

Унших нэмэлт материал: Иошуа 7; 14.

Шүүгчдийн засаглал

Шүүгчид 2; 4; 6–7; 13–16

19

Дараах судруудыг судал:

- A. Шүүгчид 2:6–23. Израилын хүүхдүүдийн гарч ирж байгаа үе удам нь хуурамч бурхдад үйлчлэхээр Их Эзэнийг орхив.
- Б. Шүүгчид 4:1–16. Барак Канааны хаан Иабинээс Израилыг чөлөөлөхөөр тушаагдав (4:1–7). Дебораг цуг явбал тэрээр явахыг зөвшөөрөв (4:8–9). Дебора ба Барак нар Израилыг Канаанчуудаас чөлөөлөв (4:10–16).
- В. Шүүгчид 6–7. Гидеон Израилыг Мидианаас чөлөөлөхөөр тушаагдав (6:1–24). Тэр өөр арван хүний хамтаар Баалын тахилын ширээг сүйтгэв (6:25–35). Их Эзэн Гидеонд туслана гэдгээ батлан түүнд хоёр тэмдгийг харуулав (6:36–40). Гидеон гурван зуун хүнтэй хамт Израилыг чөлөөлөв (7:1–25).

Г. Шүүгчид 13–16. Тэнгэр элч Самсоныг Назир хүн болгон өсгөхийг түүний эцэг эхэд зааварлав (13:1–25). Самсон хүч тэнхээтэй болж, баатарлаг үйлсүүдийг бүтээх боловч Назирын олон тангаргуудаа зөрчдөг (14–15). Самсон Делилад уруу татагдан үсээ хусуулж сул дорой болон филистчүүдэд олзлогдох бөгөөд тэдний ариун сүмийг буулгаж байхдаа үхдэг (16:1–31).

Иошуаг нас барсны дараа шүүгчид Израилын захирагчид болон цэргийн удирдагчид болов. Тэдний ихэнх ноёрхол нь эмгэнэлтэй байв. Учир нь Израил урвалт, олзлогдох, наманчлал болон чөлөөлөлт зэргийн эргэлтээр олон удаа явсан байлаа. Энэ түүхийн эмгэнэлт хэсгийг зөв шударга шүүгчдийн түүхүүдээр орлуулж болно, жишээлбэл: Дебора Гидеон хоёр үнэнч хэвээр үлдэж хүмүүсийг

чөлөөлөгдөхөд туслан, итгэл ба эр зоригоо хөгжүүлдэг.

- Үнэнч найз байхын тухайд Деборагаас бид юу сурч чадах вэ? Их Эзэний зарлигуудыг дуулгавартайгаар дагахад эсвэл хүнд хэцүү үе тулгарахад найзууд чинь та нарт хэрхэн тусалсан бэ? Бид бусдад яаж илүү сайн найз нь байж чадах вэ?
- Израилын угсааны Назир хүн учраас Самсон Их Эзэнтэй гэрээ

хийдэг. Бид Их Эзэнтэй ямар гэрээнүүд хийсэн бэ? Тэдгээр гэрээнүүд нь та нарыг хэрхэн хүчирхэг болгосон бэ?

- Самсон гэрээгээ зөрчсөнөөр ямар үр дагавартай учирсан бэ? (Шүүгчид 16:17–21-г үз.) Гэрээнүүдээ зөрчих нь бидэнд ямар хор уршигтай вэ?

Унших нэмэлт материал: “Judges, The” and “Judges, Book of,” Bible Dictionary, pages 719–20.

“Бүх хотынхон чамайг сайн эмэгтэй гэдгийг мэднэ”

20

Рут; 1 Самуел 1

Дараах судруудыг судал:

A. Рут 1–2. Нөхрөө нас барсны дараа Рут хадам ээж Ноамитай хамт Бетлехемд очив. Бетлехемд өөрт нь эелдэг ханддаг Боазын талбайд ажиллав.

B. Рут 3–4. Боазын өмнө Рут худал хэлдэг ба тэрээр түүнтэй гэрлэхийг амладаг. Тэд гэр бүл болж хүүхдтэй болов.

B. 1 Самуел 1; 2:1–2, 20–21. Ханна хүүтэй болдог ба амласан ёсоороо Их Эзэнд өгөв. Тэрээр дараа нь олон хүүхдүүдээр адислагдав.

- Ноамитай хамт Бетлехем рүү явснаар Рут юуг орхидог вэ? Ноамитай явснаар Рут юуг олж авдаг вэ? (Есүс Христийн сайн мэдээ; Рут 1:16-г үз.) Рутын жишээнээс сайн мэдээний төлөө хэрхэн золиослол хийхийг сурч чадах вэ?

- Их Эзэний үйлчлэлд Самуелыг өгөхдөө Ханна ямар сэтгэгдэлтэй байсан гэж бодож байна? Их Эзэн биднээс түүнд юугаа өгөхийг асуудаг вэ? Түүнд өгөхдөө бид ямар хандлагатай байх ёстой вэ?

- Рут, Наоми болон Ханна нар хэрхэн зөв шударгын жишээ болдог вэ?

Бурхан Өөрийг нь хүндэтгэсэн хүмүүсийг хүндэтгэнэ

21

1 Самуел 2–3; 8

Дараах судруудыг судал:

A. 1 Самуел 2:12–17, 22–25. Елигийн хөвгүүд зөрчлүүдийг гаргадаг ба эцэг нь тэдэнд зөвлөгөө өгдөг.

B. 1 Самуел 2:27–36; 3:12–14. Бурханы хүн Елид ирж түүний гэр бүл дэх ёс бус явдлын үр дагаварын талаар сэрэмжлүүлдэг.

B. 1 Самуел 3. Их Эзэн Самуелыг дууддаг ба Самуел хариулдаг.

Г. 1 Самуел 8. Израилчууд “бусад бүх үндэстнүүдтэй адил” байхын тулд хаантай байхыг хүсэв. Самуел гэдэнд энэ нь аюултай сонголт гэдгийг сэрэмжлүүлдэг.

- Елигийн хөвгүүдийн сонгосон үйлдэл нь юуг харуулж байна вэ? (1 Самуел 2:12–17, 22–25-г үз.) Ямар үед бид Их Эзэний хүсэлд тааруулахаасаа илүү өөрсдийн хүслээ дээгүүр тавьдаг вэ?
- Бурханы хүн Ели дээр ирж хөвгүүдээ Бурханаас илүү үзэж байна хэмээн түүнийг буруутгадаг (1Самуел 2:27–29). Ели хэрхэн

хөвгүүдээ Бурханаас илүү хүндэтгэсэн бэ? Бид заримдаа хэрхэн хүмүүсийг Бурханаас илүү хүндэтгэдэг вэ?

- Самуел хэрхэн Их Эзэнийг хүндэтгэсэн бэ? Их Эзэн түүнийг хэрхэн хүндэтгэсэн бэ? (1Самуел 3:19; 1 Самуел 2:30-г үз.) Бид Түүнийг хүндэтгэвэл Их Эзэн биднийг яаж хүндэтгэх вэ?

“Их Эзэн зүрх сэтгэлийг хардаг”

1 Самуел 9–11; 13; 15–17

22

Дараах судруудыг судал:

- A. 1 Самуел 9–11. Саул Самуелээс зааварчилгаа хүсэв (9:1–14, 18–24). Их Эзэн Самуелд Саул хаан болно гэдгийг илчлэв (9:15–17). Самуел Саулд зөвлөгөө өгч түүнийг Израилын анхны хаанаар тослон адисладаг (9:15–17). Саул сүнсээр дахин төрдөг ба бошиглолуудыг хэлдэг (10:9–13). Самуел Саулыг хүмүүст зарлав (10:17–27). Саул Израилыг удирдан дайнд ялав (11:1–11). Тэрээр хүмүүсийг удирдах хүчинд нь үл итгэсэн хүнийг шийтгэхээс татгалзав (11:12–15).
- B. 1 Самуел 13:1–14. Саул зохистой эрх мэдэлгүйгээр шатаалт тахилыг өргөв.
- B. 1 Самуел 15. Саул амалекчууд болон тэдний эзэмшлийн бүх зүйлсийг устгахаар тушаагдав, гэвч тэрээр тэдний зарим амьдтыг золиослолд авч үлдэв (15:1–9). Их Эзэн Саулыг хаан болгохоос татгалзсан ба Самуел Саулд дуулгавартай байдал нь золиослолоос дээр гэдгийг хэлдэг (15:10–35).
- G. 1 Самуел 16. Их Эзэн Давидыг Саулын залгамжлагч хаанаар сонгов (16:1–13). Ариун Сүнс Саулыг орхин явах ба хилэнцэт сүнс түү-

нийг эзэмшилдээ авдаг (16:14–16; Иосеф Смитийн орчуулгад эдгээр өгүүлбэрүүд нь дээрх хилэнцэт сүнс Бурханаас ирээгүйг үзүүлдэг гэдгийг анхаарна уу).

- E. 1 Самуел 17. Давид Их Эзэний хүчээр Голиатыг алав.
- Самуел Саулын амалекчуудын амьдтыг золиослолд хадгалж үлдээсэн тайлбарын хариуд юу гэсэн бэ? (1 Самуел 15:22-г үз.) Самуелын үгс бидэнд ямар хамааралтай вэ?
 - Самуел Иессигийн аль хүүг нь Саулыг залгамжлагч хаанаар сонгох вэ гэдгийг шийдэх гэж оролдож байх үедээ юу олж мэдсэн бэ? (1 Самуел 16:6–7-г үз.) 1 Самуел 16:7. Их Эзэн биднийг хэрхэн үнэлдэг талаар юуг заадаг вэ? Их Эзэн бидний зүрх сэтгэлээс юуг хайдаг вэ? Бид хэрхэн бусдын гадаад үзэмжнээс илүү тэдний зүрх сэтгэлийг харах чадвар болон тууштай байдлыг хөгжүүлж чадах вэ?
 - Давид Голиаттай тулалдах эр зоригийг хаанаас авсан бэ? (1 Самуел 17:32–37, 45–47-г үз.) Та нартай тулгарсан “Голиатыг” ялан дийлэхэд Их Эзэн та нарг хэрхэн тусалсан бэ?

Унших нэмэлт материал: 1 Самуел 12; 14.

1 Самуел 18–20; 23–24

Дараах судруудыг судал:

- A. 1 Самуел 18:1–16. Ионатан ба Давид хоёр нөхөрлөлийн гэрээ байгуулав (18:1–4). Давид тулалдаанд амжилт гарган Израилчууд түүнийг шагнав (18:5–7). Саул Давидад атаархан түүнийг алахыг завдав (18:8–16; Иосеф Смитийн орчуулгын 10-р мөрөнд Саулд ирсэн хилэнцэт сүнс нь Бурханаас *ирээгүй* гэдгийг тэмдэглэсэн байдгийг анхаарна уу).
- B. 1 Самуел 18:17–30; 19:1–18. Давид Саулын охинтой гэрлэх эрхийн төлөө филистчүүдтэй тулалддаг ба Саул Давидийг энэ тулаанд үхэхийг хүсэж байгааг мэддэггүй (18:17–25). Давид филистчүүдийг ялж, Саулын охин Михалтай гэрлэдэг (18:26–28). Ионатан Давидад нуугдахыг хэлж, Саулд түүнийг алахгүй байхыг ятгахыг оролддог (19:1–7). Саул Давидыг дахин алах гэж оролдовч амжилтгүй болно (19:9–10). Михал Давидыг Саулын өөр нэг дайралтаас аврав (19:11–18).
- B. 1 Самуел 20. Ионатан, Давид хоёр нөхөрлөл болон амар амгалангийн гэрээг дахин шинэчлэнэ. Саул

Давидийг дахин алахаар завдахад Ионатан Давидад сэрэмжлүүлдэг.

- G. 1 Самуел 23–24. Давид филистчүүдтэй тулалдаанаа үргэлжлүүлэх ба Саул зугатдаг. Давид Саулыг олж, амийг нь өршөөдөг.
- Яагаад Ионатан Давидад атаархаж түүнээс айхгүй байсан гэж бодож байна? (1 Самуел 18:1, 3.)
 - Саулыг Давидын эсрэг байхад юу нөлөөлсөн бэ? (1 Самуел 18:6–9-г үз.) Бусдын амжилтын төлөө баяртай байх нь яагаад заримдаа хэцүү байдаг вэ? Атаархал болон бардамнал нь бидний сүнслэг сайн сайханд яаж нөлөөлдөг вэ?
 - Ионатан болон Давидын нөхөрлөлд Бурханд итгэх итгэл хэрхэн нөлөөлсөн бэ? (1 Самуел 20:23-г үз.) Бидний Бурханыг хайрлах хайр бусдыг хайрлах хайранд хэрхэн нөлөөлдөг вэ?
 - Давидын жишээ нь өс хонзонгийн талаар бидэнд юуг заадаг вэ? (1 Самуел 24:6–15-г үз.)

Унших нэмэлт материал: 1 Самуел 14:1–16; 2 Самуел 1.

“Миний дотор цэвэр зүрхийг бүтээ”

2 Самуел 11–12; Дуулал 51

Дараах судруудыг судал:

- A. 2 Самуел 11. Давид Уриагийн эхнэр Батшебатай садар самуун явдал үйлдэв (11:1–5). Давид өөрийн нүглээ нууж чадалгүй баригдав (11:6–13). Тэрээр Уриагийн аллагыг зохион байгуулав (11:14–17). Давид Батшебатай гэрлэдэг ба тэд хүүтэй болно (11:26–27).

- B. 2 Самуел 12:1–23. Бошиглогч Натан Давидын нүглийн хүндийг сургаалт үлгэрээр сургадаг (12:1–6). Түүний нүглийн улмаас Давид шийтгэгдэх болно гэдгийг хэлдэг (12:7–14; Иосеф Смитийн орчуулгын 13-р мөрөнд Натан “Их Эзэн таны нүглийг зайлуулаагүй тул та үхэх ёсгүй” гэдгийг тэмдэглэдэг”). Давид Батшеба нарын анхны хүү нярайдаа өнгөрөв (12:15–23).

В. Дуулал 51. Нүглээ наманчилсан Давид өршөөл эрдэг.

Давид Саулыг залгамжлагч хаан болдог ба Израилын түүхэн дэх гайхамшигт хаадын нэг болдог. Тэрээр овог аймгуудыг нэгтгэн нэгэн үндэстэн болгож, түүний хүмүүст амлагдсан газрыг хамгаалан Бурханы хуульд үндэслэсэн засгын газартай болдог. Гэсэн хэдий ч амьдралынх нь сүүлийн хорин жил нь түүний үйлдсэн нүглийн нөлөөтэй холбоотой байв.

- Давидын ямар үйлдэл нь түүнийг садар самуун үйлдэхэд хүргэсэн бэ? (2 Самуел 11:2–4-г үз.) Хүмүүсийг садар самуун явдал үйлдэхэд юу уруу татдаг вэ? Садар самуун явдлын уруу таталтаас бид хэрхэн сэргийлж чадах вэ?
- Өөрийн садар самуун явдлаа нуухыг оролдохдоо Давид ямар илүү хүнд нүглийг үйлдсэн бэ? (2 Самуел

11:14–17.) Давид хэнээс өөрийн нүглээ нуухыг оролдсон гэж та нар бодож байна вэ? Хүмүүс хэрхэн нүглээ далдлахыг оролддог вэ? Бид нүглүүдээ далдлахыг оролдвол юу болох вэ?

Их Эзэнд өргөсөн дуулалд Давид бусдад нүглээ наманчлахад нь туслахыг хүсэн, “Би нүгэлтнүүдэд таны замыг заах бөгөөд нүгэлтнүүд тань руу буцаж ирэх болно” гэдэг (Дуулал 51:13). Хэдийгээр Давид Уриагийн үхлийг зохион байгуулан өргөмжлөө алдсан ч бид түүний садар самуун явдлын нүглээ наманчлахыг эрэлхийлсэн зан чанараас суралцаж чадна. Түүний Дуулал 51-дэх үгс нь үнэн наманчлалын олон талуудыг заадаг. Дууллыг судалснаар та нар Давидын наманчлалын жишээг өөрийн амьдралдаа тусгаж болох замуудыг хай.

Унших нэмэлт материал: 2 Самуел 2–10.

“Амьтай бүхэн Их Эзэнийг магтагтун”

Дуулал

25

Дараах судрууд болон дууллаас судал.

Дуулал ном нь яруу найргуудын цуглуулга бөгөөд анхандаа Бурханы алдрыг бадруулах буюу мөргөл болгон дуулдаг байсан. Ихэнхийг нь Давид бичсэн байдаг. Энэ ном нь эртний Израилчуудын дууны ном байсан.

Олон дууллууд нь Христийн Мессиагийн номлолын талаар бошиглодог. Дуулал номонд бичигдсэн Христийн талаарх бошиглолыг анхаарна уу?

<u>Бошиглол</u>	<u>Хэрэгжилт</u>
Дуулал 69:20	Марк 14:32–41
Дуулал 22:7–8	Матай 27:39–43
Дуулал 22:16	Марк 15:25

<u>Бошиглол</u>	<u>Хэрэгжилт</u>
Дуулал 22:18	Матай 27:35
Дуулал 22:1	Матай 27:46
Дуулал 16:10	Үйлс 2:31–32; 13:34–35

Аврагчийн нигүүсэл, өршөөл болон хайранд талархлаа илэрхийлсэн дууллууд: Дуулал 23; 51; 59:16; 78:38; 86:5, 13; 100:4–5; 103:2–4, 8–11, 17–18.

Их Эзэнд итгэхийн чухлыг заасан дууллууд: Дуулал 4:5; 5:11; 9:10; 18:2; 56:11; 62:8; 118:8–9.

Ариун Сүмийн тухай дууллууд: Дуулал 5:7; 15:1–3; 24; 27:4; 65:4; 84:1–2, 4, 10–12; 122; 134.

Хаадын Дээд 3; 5-11

Дараах судруудыг судал:

- A. Хаадын Дээд 3:5-28. Соломон түүний эцэг Давидыг залгамжлан хаан болдог бөгөөд Их Эзэнийг дагадаг. Их Эзэн Соломонд үзэгддэг ба түүнийг мэргэн ухаан, баялагууд болон алдар суугаар адисалдаг (3:5-15). Хоёр эмэгтэй Соломонд нэг хүүхдийг авчирдаг ба тэрээр хэн нь хүүгийн ээж болохыг мэргэн ухаанаар шийддэг (3:16-28).
- B. Хаадын Дээд 5-6; 7:1-12. Соломон хаан алдарт ариун сүмийн барилгыг удирддаг (5-6). Тэрээр өөртөө ордон барьдаг (7:1-12).
- B. Хаадын Дээд 8:22-66; 9:1-9. Соломон ариун сүмийг онцгойлон адисладаг ба Их Эзэнээс Израилчуудыг сүнсний болон зуурдын цэцэглэлтээр адислахыг гуйдаг (8:22-66). Их Эзэн Соломонд дахин үзэгдэж хэрэв Түүнд үйлчилвэл тэднийг адислах бөгөөд өөр бурхдын зүгт хандвал зүхэхээ амладаг (9:1-9).
- G. Хаадын Дээд 10-11. Соломон эд баялаг болон мэргэн ухаанаараа алдар цуутай болов (10:1-13, 24-25). Тэрээр маш их баян болов (10:14-23, 26). Тэрээр Израилчуудын удмын биш олон эхнэрүүдтэй байсан ба тэдгээр нь түүний сэтгэлийг урвуулан өөр бурхдад дагуулж байв (11:1-10). Соломоны ёс бус явдлаас болон Израилын хаант улс задрах

болно хэмээн бошиглогч хэлж байв (11:26-40).

- “Ухааран ялгах чадвар”-тай байх гэдэг нь юу гэсэн үг вэ? (Хаадын Дээд 3:28; 4:29-г үз.) Соломон яагаад энэ адислалыг онцгойлон хэрэгтэй гэж үзсэн бэ? (Хаадын Дээд 3:7-8-г үз.) “Бурхны мэргэн ухаан”-тай байснаар гэр бүл, ажил, сургууль болон сүмд хүлээх үүрэг хариуцлагуудад маань хэрхэн туслаж чадах вэ? Энэ мэргэн ухааныг бид хэрхэн хүлээн авч чадах вэ?
- Их Эзэн ариун сүмтэй холбоотой ямар амлалтуудыг Соломонд өгсөн бэ? (Хаадын Дээд 6:11-13-г үз.) Их Эзэн өнөөдөр бидэнд ямар ижил төстэй амлалтыг өгсөн бэ? (С ба Г 97:15-17-г үз.) Бид өөрсдийн амьдралдаа ариун сүмийн хүчтэй нөлөөг хэрхэн хадгалж чадах вэ?
- Ариун сүм баригдсаны дараа Соломоны эд баялаг, алдар цуу яаж өссөн бэ? (Хаадын Дээд 10:1-15, 24-25-г үз.) Эдгээр адислануудыг Соломон хэрхэн буруу ашигласан бэ? (Хаадын Дээд 10:16-23, 26-29-г үз.) Мэргэн ухаан, эд баялаг болон алдар цуу хэрхэн хэрэглэгдэх ёстой вэ? (Иаков 2:18-19-г үз.)

Унших нэмэлт материал: Хаадын Дээд 2:1-12; 4:29-34; 7:13-51; Шастирын Дээд 29; Сургаал ба Гэрээ 46.

Зөв шударга болон ёс бус удирдагчдын нөлөө
Хаадын Дээд 12-14; Шастирын Дээд 17; 20

Дараах судруудыг судал:

- A. Хаадын Дээд 12:1-20. Эцэг Соломоноо залгамжлан Рехобоам Израилын арван хоёр овгийн хаан болов. Тэрээр хүмүүстэй үйлчил

гэсэн ухаант хүмүүсийн зөвлөгөөг эсэргүүцэн тэдэнд илүү хүнд ачаа үүрүүлэхийг эрэлхийлдэг (12:1-15). Хаант улс арван овог болон босдог (12:16-19; арван овог Израилын гэр

бүл гэдэг нэрээрээ үлддэг ба харин Иуда ба Бениаминий овгууд Рехобоамын захиргаан дор үлдэн Иудагийн хаант улс хэмээн нэрлэгддэг).

- В. Хаадын Дээд 12:25–33; 13:33–34; 14:14–16, 21–24. Иеробоам хүмүүсээ хуурамч бурхдыг тахин шүтэхэд удирдав (12:25–33; 13:33–34). Бошиглогч Иеробоамын гэр бүлийн хуваагдал болон Израилын таралтын талаар зөгнөв (14:14–16). Рехобоам хаант улсаа хуурамч бурхдыг тахин шүтэхэд удирдав (14:21–24).
- В. Шастирын Дэд 17:1–10; 20:1–30. Рехобоамын гуч хүү Иехошафат Иудагийн хаант улсыг үнэнчээр удирдав (17:1–10). Иудагийн дайснууд ирэхэд Иехошафат болон түүний хүмүүс мацаг барин залбирдаг байв. Их Эзэн тэдэнд тулаан нь тэд-

нийх биш түүнийх юм гэдгийг хэлдэг. Тэдний дайснууд өөр хоорондоо дайтан бие биеэ хөнөөдөг байв (20:1–30).

- Сайн удирдагч байхын тухайд ахмадууд Рехобоамд ямар зөвлөгөөг өгсөн бэ? (Хаадын Дээд 12:6–7; Шастирын Дэд 10:7-г үз.) Энэхүү зөвлөгөөг бид яаж гэр, ажил, сургууль болон сүмдээ хэрэгжүүлж чадах вэ?
- Иехошафат Иудагийн хүмүүсийг Их Эзэний өмнө даруу төлөв байхад нь нөлөөлдөг (Шастирын Дэд 20:3–4). Зөв шударга удирдагчийн ямар жишээнүүдийг та нар үзсэн бэ? Бид үйлчилдэг хүмүүсдээ зөв шударга амьдрахад нь хэрхэн нөлөөлж чадах вэ?

Унших нэмэлт материал: Хаадын Дээд 11:26–40; Хаадын Дэд 17:20–23

“Тал гарсны дараа намуухан хүнгэнэх дуу гарлаа”

Хаадын Дээд 17–19

Дараах судруудыг судал:

- А. Елиа бороо оруулахгүйгээр тэнгэрийг хаан, Ахаб болон Зарефатаас зугтаан элүүд талд гайхалтайгаар амьдарч байв (17:1–6). Их Эзэн Елиаг бэлэвсэн эмэгтэй рүү илгээх бөгөөд тэр түүнд хоол болон ус өгч байв (17:7–16). Елиа бэлэвсэн эмэгтэйн хүүг үхлээс амилуулав (17:17–24).
- В. Хаадын Дээд 18. Хоёр жил гаруй үргэлжилсэн өлсгөлөнгийн дараа Елиа Ахабтай уулзан тэнгэрээс галыг дуудан тэдний тахилыг шатаалгахаар Баалын санваартнуудыг сорив (18:1–2, 17–24). Баалын санваартнууд ингэж чаддаггүй бөгөөд Елиа Их Эзэнд залбирсанд гал буун ирж түүний бэлтгэсэн тахилыг шатаав (18:25–40).
- В. Хаадын Дээд 19. Иезебел Елиаг алахаар завдав (19:1–2). Елиа элүүд тал-

руу зугатаахад тэнгэр элч түүнийг хооллож байв (19:3–8). Елиа Хоробд очих ба Ариун Сүнс түүнийг тайвшруулан Бурханы ажлыг үргэлжлүүлэхэд нь зөвлөдөг (19:9–19).

Иеробоам Израилыг хуурамч бурхдыг тахин шүтэхэд удирдсаны дараа тэрээр өөрийн удмынхантайгаа хамт устгагдав. Тэднийг бас өөр бурхдыг тахин шүтэгч хаадууд залгамжлав. Эдгээр удирдагчдын дотор “Ахаб өөрийн өмнөх Израилийн бүх хаадаас ч илүүгээр Израилын Их Эзэн Бурханыг хилэгнүүлэх зүйл хийв” (Хаадын Дээд 16:33). Тэр Иезебелтэй гэрлэж түүний Баалын тахин шүтэх ёсыг аван, хүмүүсээ энэ хуурамч бурхныг тахин шүтэх ёсондоо орохыг дэмжиж байв. Елиа Ахабад болон түүний хаант улсад сэрэмжлүүлэх үгсийг тарааж байв.

- Өөрийгөө болон хүүгээ тэжээхээсээ өмнө Елиаг хоолло гэж Их Эзэн яагаад бэлэвсэн эмэгтэйд тушааж байсан бэ? (Хаадын Дээд 17:14–16-г үз.) Биднийг амьдралдаа Бурханы зүйлсийг нэгдүгээрт тавихыг ямар замаар асуудаг вэ?
- Кармел уулан дээр хүмүүс Елиаг сонсохоор ирэхэд “Та бүхэн хэдий болтол хоёр замын хооронд тээнэ-гэлзэх юм бэ?” хэмээн асуудаг.

Заримдаа бид яаж хоёр замын хооронд тээнэгэлздэг вэ?

- Хороб уулан дээр Бурхан хэрхэн Елиаг тайвшруулсан бэ? (Хаадын Дээд 19:9–13-г үз.) Энэ түүхээс Бурхан бидэнтэй хэрхэн харилцдаг талаар юу мэдэж чадах вэ? Бурхан ихэнх тохиолдолд сүр хүчтэй илэрхийллээс илүү Ариун Сүнсний “намуун хүнгэнэх дуугаар” харилцдаг. Бид яаж Ариун Сүнсний шивнэлтийг ялгаж таньж чадах вэ?

“Тэр Елиагаас унасан нөмрөгийг авч...”

Хаадын Дэд 2; 5–6

29

Дараах судруудыг судал:

- A. Хаадын Дэд 2:1–18. Елишаг шинэ бошиглогч болоход нь Елиа бэлтгэв (2:1–10). Елиа тэнгэр уруу авагдав. Елиша Елиагийн нөмрөгийг аван шинэ бошиглогч болов (2:11–15). Елишагийн зөвлөгөөг үл тоон тавин хүн Елиаг гурван өдрийн турш хайв (2:16–18).
- B. Хаадын Дэд 5. Елиша Нааманы уяман өвчнийг эмчлэв (5:1–14). Нааман Бурханыг магтан Елишаг шагнасан боловч Елиша үүнээс нь татгалзав (5:15–19).
- B. Хаадын Дэд 6:8–18. Елиша Израилын хааныг Самартай хийсэн дайнд удирдав (6:8–10). Самарын хаан өөрийн хүмүүсдээ Елишаг баривчлахыг тушаасан бөгөөд цэргүүд нь Дотан хотыг эзлэв (6:11–14). Елиша үүнээс айхгүйгээр залбирах бөгөөд Их Эзэн уул дүү-

рэн галт морьд, цэргүүд өгөн Самарын цэргүүдийг сохор болгов (6:15–18).

- Бид дургүй, ойлгохгүй эсвэл дагахад хялбар биш зүйлс байсан ч бошиглогчдын зөвлөгөөг дагах тухай Нааманы түүх бидэнд юуг зааж чадах вэ? Бошиглогч болон сүмийн бусад удирдагчдын биднээс дагахыг хүссэн ямар энгийн хялбар зүйлс байна вэ? Яагаад эдгээр нь заримдаа хийхэд хэцүү байдаг вэ? Сүмийн удирдагчдын зөвлөгөөг дуртайгаар дагах хүслээ бид хэрхэн өсгөж чадах вэ?
- “Бидэнтэй хамт байгчид нь тэдэнтэй хамт байгчдаас илүү олон юм” гэж Елиша үйлчлэгчиддээ хэлсэн нь ямар утгатай вэ? (Хаадын Дэд 6:16). Елишагийн энэ тунхаг нь өнөөдөр ч үнэн гэдэг нь та нарт хэрхэн харагдаж байна вэ?

“Их Эзэний өргөө уруу ир”

Шастирын Дэд 29–30; 32; 34

30

Дараах судруудыг судал:

- A. Шастирын Дэд 29–30. Иудагийн хаан Хезекиа ариун сүмүүдийн хаалгыг онгойлгон санваартнууд болон

левичүүдийг шүтэн бишрэх үйлдлүүдэд зориулан цэвэрлэн ариусгахыг зөвлөв (29:1–19). Ариун сүм бэлэн болсны дараа Хезекиа хүмүүс-

тэйгээ Их Эзэнийг шүтэн биширч магтан дуулав (29:20–36). Хезекиа бүх Израилчуудыг Иерусалим дах ариун сүмд ирэхийг урив (30:1–9). Зарим хүмүүс шоолон инээж байсан ч итгэлтэй израилчууд Иерусалимд Их Эзэнийг шүтэн биширч байв (30:10–27).

В. Шастирын Дэд 32:1–23. Ассирийн хаан Сеннахериб Иудаг эзлэн авч Их Эзэнийг эсрэг ярьж байв (32:1–19). Исаиа ба Хезекиа нар тусламж гуйн залбирахад Их Эзэнийг тэнгэр элч Ассирийн цэргийн ихэнхийг сүйтгэв (32:20–23).

В. Шастирын Дэд 34. Хезекиагийн хүү болон ач хүү нар нь ёс бус явдлаар удирдаж байсны дараа Хезекиагийн гуч хүү Иосиа Иудагийн хаан болов. Иосиа хаант улсынхаа шүтээнүүдийг нурааж ариун сүмүүдийг засварлав (34:1–13). Хуулийн номыг

ариун сүмээс олсон бөгөөд Иосиад уншин өгөхөд тэрээр хүмүүс хуулиас хэр хол төөрснийг мэдэх бүртгээ уйлж байв (34:14–21). Иосиа болон түүний хүмүүс Их Эзэнд үйлчлэхээр гэрээ хийв (34:29–33).

- Хезекиагаас бид өөрсдийн хүчиндээ итгэх болон Их Эзэнд итгэх хоорондын зохистой харилцааны талаар юу мэдэж чадах вэ? (Шастирын Дэд 32:7–8-г үз.)
- Иосиа хүмүүстэйгээ ариун сүмд байхдаа ямар гэрээг байгуулсан бэ? (Шастирын Дэд 34:31–33-г үз.) Ариун сүмийн нандин гэрээнүүдийг хийхдээ бид хэрхэн бэлдэж чадах вэ? Эдгээр гэрээнүүдийг хийснийхээ дараа боломж гарах бүртгээ ариун сүмд ирж байх нь яагаад чухал байдаг вэ?

Унших нэмэлт материал: Хаадын Дэд 18–19; 22–23; Исаиа 37:10–20, 33–38.

“Мэргэн ухааныг олдог хүн ерөөлтэй ээ”

Сургаалт Үгс ба Номлогчийн Үгс

31

Энд ярилцсан судрууд болон Сургаалт Үгс, Номлогчийн Үгс номуудаас боломжийнхоо хэрээр судал.

Сургаалт Үгс нь ерөнхийдөө зөв шударга амьдрах тухай товч зөвлөгөөнүүд юм. Хуучин Гэрээнд Соломон “гурван мянган сургаалт үг хэлсэн” гэж тэмдэглэсэн байдаг (Хаадын Дээд 4:32). Эдгээр мэргэн үгсийн зарим нь Сургаалт Үгс номонд багтсан. Соломон болон энэ номны бусад зохиогчид нь бошиглогчид биш боловч тэдний бичсэн зүйлсийн ихэнх нь Их Эзэнийг урмаар бичигдсэн байдаг. Номлогчдын үгс нь мэргэн үгсийг багтаасан байдаг бөгөөд заримыг нь Соломон бичсэн гэдэгт зарим хүмүүс итгэдэг.

- Сургаалт Үгс ба Номлогчдын үгс нь мэргэн ухааны чухлыг онцол-

сон байдаг. Мэдлэгтэй болон ухаалаг байх хоёрын ялгаатай талууд нь юу вэ? (Сургаалт Үгс 1:7; 9:9–10; 2 Нифай 9:28–29-г үз.)

- Сургаалт Үгс 3:5–7-д ямар зөвлөгөөг өгсөн байдаг вэ? Ямар тохиолдлууд та нарт Их Эзэнд итгэхийг заасан бэ?
- Яагаад Их Эзэнд бидний ярьж байгаа үгс хамаатай байдаг вэ? (Сургаалт Үгс 16:27–28; 18:8; 25:18; Матай 12:36–37-г үз.) Худал хэлэх, хов ярих болон бусдын талаар тааламжгүй зүйлс ярих зэрэг асуудлуудыг бид хэрхэн давж чадах вэ?
- Сургаалт Үгс 13:10 ба 16:18-д бардамнал нь зөрчилдөөн ба устгалд хүргэдэг хэмээн заадаг. Бардамнал нь хэрхэн ингэж чадах вэ? Бардамнал бидний гэр бүлүүдэд яаж нөлөөлөх вэ?

- Сургаалт Үгс 22:6-д “явах ёстой замаар нь замнуулахын тулд хүүхдийг сурга” гэсэн байдаг. Энэ зөвлөгөөг дагахын тулд эцэг эхчүүд юу хийх ёстой вэ? (С ба Г 68:25–28-г үз.) Хүүхдүүддээ сайн мэдээний зарчмуудыг илүү үр ашигтай заахын тулд эцэг эхчүүд юу хийж чадах вэ?

- Баяр хөөртэй болон хөгжилтэй зан чанартай байх нь яагаад чухал вэ? (Сургаалт Үгс 15:13; 17:22 –г үз.) Гэр бүлдээ урамшуулсан, хөгжилтэй байдлыг хөгжүүлэхийн тулд бид юу хийж чадах вэ?

“Миний Гэтэлгэгч амьд гэдгийг би мэднэ”

Иов 1–2; 13; 19; 27; 42

32

Дараах судруудыг судал:

- А. Иов 1–2. Иовд маш хүнд олон зовлон зүдгүүр тулгардаг. Тэрээр эд хөрөнгө, хүүхдүүд, эрүүл мэндээ алдсаныг үл харгалзан Их Эзэнд итгэлтэй хэвээр үлддэг.
- Б. Иов 13:13–16; 19:23–27. Их Эзэнд болон Аврагчийн талаарх өөрийн гэрчлэлд итгэснээр Иов хүч чадлыг олдог.
- В. Иов 27:2–6. Иов өөрийн зөв, шулуун шударга байдалдаа хүч чадлыг олдог.
- Г. Иов 42:10–17. Иовыг зовлон зүдгүүрүүдийг итгэлтэйгээр туулсны дараа Их Эзэн түүнийг адисладаг.
- Иов ямархуу хүн байсан бэ? Иовд ямар зовлон зүдгүүрүүд тулгарсан бэ?
- Аврагчийн талаарх гэрчлэл нь Иовд зовлон зүдгүүрээ даван туу-

лахад нь хэрхэн тусалсан бэ? (Иов 19:25–27-г үз.)

- Иовийн зовлонгуудын үед шулуун шударга байдал нь сүнслэг хүч чадлын бас нэгэн эх үүсвэр болж байсан (Иов 27:2–6). Шулуун шударга байдал гэж юу вэ? Зовлон зүдгүүрийн үед түүний шударга байдал нь Иовийг хэрхэн хүч чадалтай болгож байсан бэ? Бидний хүнд хэцүү үед хувийн шулуун шударга байдал бидэнд хэрхэн тусалж чадах вэ?
- Иов итгэлтэйгээр зовлон зүдгүүрүүдээ туулсны дараа Их Эзэн түүнийг хэрхэн адисласан бэ? (Иов 42:10–15; Иаков 5:11-г үз.) Бид итгэлтэйгээр зовлон зүдгүүрүүдийг давахад Их Эзэн биднийг хэрхэн адисладаг вэ? (Иов 23:10; 3 Нифай 15:9-г үз.)

Унших нэмэлт материал: Иовийн бусад бүлгүүд; Сургаал ба Гэрээ 121:1–10.

Сайн Мэдээг дэлхийтэй хуваалцах нь

Иона 1–4; Мика 2; 4–7

33

Дараах судруудыг судал:

- А. Иона 1–2. Их Эзэн Ионаг Ниневегийн хүмүүст наманчлалыг номло хэмээн дууддаг. Иона Их Эзэнээс завиар зугатаадаг боловч аварга загас түүнийг залгиж, залбирснаар загасны гэдэснээс гарч ирдэг.

- Б. Иона 3–4. Иона Ниневегийн уналтын талаар бошиглодог. Ниневегийн хүмүүс наманчилснаар Их Эзэн хотыг зүгээр орхисонд Иона уурладаг (Иосеф Смитийн Орчуулгын Иона 3:9–10 Бурхан биш хүмүүс наманчилсан гэдгийг тайлбарладаг).

В. Мика 2:12–13; 4:1–7, 11–13; 5:2–4, 7–8; 6:6–8; 7:18–20. Мика эцсийн өдрүүд дэх Израилын номлолыг бошиглодог.

- Их Эзэн яагаад Ионаг Ниневеруу явуулахыг хүссэн бэ? (Иона 1:2-г үз.) Иона оронд нь яагаад Иоппаруу явсан бэ? Бид сайн мэдээг хуваалцахгүйгээр шийддэг ямар шалтгаанууд байдаг вэ? Ионагийн түүхээс суралцсанаар Их Эзэнийг дуулга-

вартайгаар даган, сайн мэдээг хуваалцахдаа илүү зоригтой байхад бидэнд яаж туслаж чадах вэ?

- Мика хожмын өдрүүдийн ариун сүмийн талаар юу бошиглосон байдаг вэ? (Мика 4:1–2-г үз.)
- Биднээс хүсэн хүлээдэг бүх зүйл биднийг тэвдэн барьц алдахад хүргэсэн үед Мика 6:6–8 бидэнд хэрхэн тусалж болох вэ?

“Би зөв шударга байдлаар чамтай сүй тавина” 34

Хосеа 1–3; 11; 13–14

Дараах судруудыг судал:

А. Хосеа 1–3. Бошиглогч Хосеа итгэлтэй нөхөр болон садар самуун явдалт эхнэрээр төсөөлүүлэн Их Эзэн ба Израилын хоорондын харилцааг харуулдаг. Эдгээр бүлгүүдэд Хосеа нөхөр нь Их Эзэнийг, Израилыг Гомер эхнэрээр төлөөлүүлдэг.

В. Хосеа 11; 13–14. Их Эзэн өөрийн хүмүүст хайртай учраас тэрээр Израилыг наманчлан түүнд буцан ирэхэд урьсаар байдаг.

- Хосеа 1–3-н харьцуулалт нь Их Эзэний биднээс хүлээсэн амлал-

тууд ба сүсэг бишрэлтэй байдлын түвшингийн талаар бидэнд юуг заадаг вэ?

- Хэн эсвэл юу хүмүүсийг Их Эзэнээс нүүр бууруулахад хүргэдэг Израилын “хайртууд”—ын зүйлс вэ?
- Хэрэв эхнэр нь түүнд буцаж ирвэл нөхөр нь юуг амладаг вэ? (Хосеа 2:19-ийг үз.) Хэрэв түүнрүү буцаж ирж наманчилбал Их Эзэн хүмүүсдээ юуг амладаг вэ? (Хосеа 2:20, 23-г үз.)

Унших нэмэлт материал: Хосеагийн үлдсэн бүлгүүд.

Бурхан нууцуудаа бошиглогчиддоо илчилдэг

Амос 3; 7–9; Иоел 2–3

Дараах судруудыг судал:

А. Амос 3:6–7. Амос Их Эзэн өөрийн нууцуудыг бошиглогчид илчилдэг болохыг заадаг.

В. Амос 7:10–17; 8:11–13; 9:8–15. Их Эзэн Амосыг бошиглогчоор дууддаг (7:10–15). Тэрээр Израилыг олзлогдож тараагдах талаар бошиглодог (7:16–17; 9:8–10). Мөн Их Эзэний үгийг сонсохын төлөө өлсгөлөн

болох болно хэмээн бошиглодог (8:11–13). Тэрээр эцсийн өдрүүдэд Израил агуу их чинээлэг хүмүүс байх болно гэдгийг бошиглодог (9:11–15).

- В. Иоел 2; 3:16–17. Иоел эцсийн өдрүүдийн дайн тулаан ба байгалийн гай гамшгийн талаар бошиглодог (2:1–11). Тэрээр хүмүүсийг наманчлалд дууддаг (2:12–14;

35

Иосеф Смитийн орчуулгад 13 ба 14-р шүлгүүд Их Эзэн биш хүмүүсийг наманчлахыг тайлбарладаг). Иоел Бурхан хүмүүсээ хожмын өдрүүдэд адислах ба өөрийн Сүнсээ тэдэн дээр цугтах болно гэдгийг бошиглодог (2:15–32; 3:16–17).

МЭӨ 800–750оны үед Израилын хаант улсын хүмүүст Амос тунхаглаж байсан. Эдгээр хүмүүсийн ихэнх нь урвалтанд байсан. Амос хүмүүст нүглүүдийг нь хэлж, хурц шийтгэлүүдийг бошиглодог байсан. Гэсэн хэдий ч Бурхан наманчилсан хэнийг ч ариусгахад бэлэн гэдгийг онцолдог. Мөн Амос хожмын өдрүүдийн талаар бошиглодог.

Иудагийн хаант улсын хүмүүст Иоел тунхагладаг. Иоелийн ихэнх бошиглолууд нь хожмын өдрүүдийн талаар байдаг.

- Бошиглогч Амос бошиглогчдын чухлын талаар юу заасан бэ? (Амос 3:7-г үз.) Сургаал ба Гэрээ 1:37–38

бидний бошиглогчдын номлолын талаарх хүндэтгэлийн тухай юу заадаг вэ?

- Хэрэв Израил бошиглогчдын номлолуудыг эсэргүүцэх юмуу үл тоовол ямар үр дагавартайг Амос юу гэж бошиглосон бэ? Их Эзэний үгийн байхгүйг ямар замаар өлсгөлөнтэй адилтгаж болох вэ? Дахин сэргээгдсэн сайн мэдээний адислалыг хэрхэн найр хуримтай адилтгаж болох вэ?
- Иоел 2:12–32 ба 3:16–17-г дахин хэлэлцэн дараах асуултуудын хариултаудыг ол: Хожмын өдрүүдэд амьдарч байгаа хүмүүст Их Эзэн ямар урилгыг өгсөн бэ? Хожмын өдрүүдэд түүнийг дагасан хүмүүст Их Эзэн ямар адислалуудыг амласан бэ?

Унших нэмэлт материал: Иосеф Смит-Түүх 1:41; Сургаал ба Гэрээ 1:14–28, 37–38.

Сионы алдар суу хамгаалалт болно

Исаиа 1–6

Исаиа 1–6-г судал

Исаиа Аврагчийн дэлхий дээрх номлол, Израилын хилэнцийн дараах сүйрэл, хожмын өдрүүдийн Израилын номлол ба тавилангийн талаар олон зүйлсийг бошиглодог.

- Исаиагийн сэрэмжлүүлэг ба бошиглолуудын ихэнх нь түүний цаг үе болох маш их ёсон бус явдлуудаар дүүрэн үед болон бидний энэ цаг

үед зориулагдсан байдаг. Исаиа1–5-д дүрслэгдсэн нөхцлүүд өнөөдрийн дэлхийд яаж илэрсэн бэ?

- Исаиа 4:5–6-д гардаг хилэнцээс аврах гурван аюулгүй газрууд нь юу вэ? Эдгээр ариун газар нь биднийг хэрхэн хамгаалах талаар эдгээр шүлгүүд ямар илэрхийллээр дүрсэлсэн бэ?

Унших нэмэлт материал: 2 Нифай 11.

36

“Та нар гайхамшигт зүйлсийг хийсэн”

Исаиа 22; 24–26; 28–30

Дараах судруудыг судал:

А. Исаиа 22:22. Аврагч Тэнгэр Эцэгийн оршихуйн хаалгыг нээв.

Б. Исаиа 24:21–22. Аврагч сүнсний шоронгийнхонд нигүүлсэл үзүүлэв.

В. Исаиа 25:1–4; 32:1–2. Аврагч хүч чадал ба хамгаалал.

37

Г. Исаиа 25:6–9. Аврагч хурим найрыг бэлтгэн “

Д. Исаиа 25:8. Аврагч бидний нулимсыг арчдаг.

Е. Исаиа 26:19. Аврагч Амилуулалтыг авчрах болно.

Ё. Исаиа 28:16. Аврагч бидний найдвартай суурь юм.

Ж. Исаиа 29:4, 9–14, 18, 24. Аврагч сайн мэдээг дэлхий дээр дахин сэргээнэ.

З. Исаиа 30:19–21. Аврагч бидний зовлон зүдгүүрүүдийг мэддэг ба бидний замыг зааж байдаг.

- Аврагч “бидний нулимсыг хэрхэн арчдаг” вэ? (Исаиа 25:8).
- Исаиа Мессиа үхээд дахин амилах болон хэзээ ирэх зэргийг бошиглонсон байдаг (Исаиа 25:8). Өөр хэн хэнийг дахин амилуулах вэ? (Исаиа 26:19; 1 Коринт 15:20–22; Алма

11:43–44-г үз.) Бид дахин амиласныхаа дараа ямар сэтгэгдэлтэй байх талаар Исаиа 26:19-д юу хэлсэн бэ? (С ба Г 138:12–16, 50 –ийг мөн үз.)

Исаиагийн зарим нэг бошиглоууд хэрхэн биелснийг Исаиа 29-ийн дараах шүлгүүд болон тохирох үйл явдлуудтай харьцуул:

Исаиа 29:4 Моронай 10:27

Исаиа 29:9–10, Иосеф Смит-Түүх 13 1:18–19

Исаиа 29:11–12 Иосеф Смит-Түүх 1:63–65

Исаиа 29:14 Сургаал ба Гэрээ 4:1; 6:1

- Исаиа хүмүүс амаараа Их Эзэнд ойртон, зүрх сэтгэлээрээ Түүнээс холдож байна гэдгийг хэлдэг (Исаиа 29:13). Бид санаа бодол, үйл хөдлөл, үг хэлээрээ Их Эзэнтэй хамт байгаага хэрхэн мэдэж чадах вэ?

“Надаас өөр Аврагч байхгүй”

Исаиа 40–49

38

Исаиа 40–49-ийг судал.

- Исаиа 40:28–31; 42:16; 43:1–4; 44:21–23; ба 49:14–16-г дахин ярилц. Судар бүрийг уншиж байхдаа дараах асуултуудад тохирох хариултуудыг хай: Энэ үйл явдал нь Аврагчийн ямар шинж чанарыг гаргасан бэ? Энэ шинж чанарыг мэдсэнээр Аврагчид итгэх бидний итгэл нэмэгдэхэд яаж туслах вэ?
- Ихэнхдээ судруудад Вавилон нь дэлхийн ёс бус явдлын билэг тэмдэг болон хэрэглэгддэг. Дэлхийн арга

замаар явахын үр дагавар нь юу вэ? (Исаиа 47:1, 5, 7–11-г үз.) Дэлхийн зүйлсийн араас явахын оронд өөрийнх нь араас явбал Их Эзэнд тэдэнд юуг амласан бэ? (Исаиа 48:17–18-г үз.)

- Исаиа 49-ийн олон бошиглоууд нь Аврагчийн ажил болон түүний үйлчлэгчдийн ажилтай холбоотой байдаг. Исаиа 49:1–6 нь бидний хожмын өдрүүдийн үүрэг хариуцлагын талаар юу заадаг вэ?

Исаиа 50–53-ыг судал.

- Исаиа 53:2–5. Аврагчийн амьдралын талаар юу гэсэн байдаг вэ? Тэр яагаад бидний уй гашуу, уйтгар гунигийг ойлгож чаддаг вэ? (Алма 7:11–13; Еврей 2:16–18; 4:15-г үз.) Та нарын уй гашуу ба уйтгар гунигыг тэр ойлогодог гэдгийг чи яаж мэдрсэн бэ? Аврагч яагаад шархдаж бэртэн, ташуурдуулахын өвдөлтөөр зовж шаналахад бэлэн байсан бэ? (1 Нифай 19:9-г үз.)
- Аврагчийн цагаатгалтай холбоотой хэд хэдэн үйл явдлуудыг Исаиа

бошигласон байдаг. Дараах шүлгүүд Аврагчийн хайр болон түүний цагаатгалын золиослолын талаар юу заадаг вэ?

Исаиа 50:5–7 (мөн Матай 26:39; Филемон 2:8-ыг үз.)

Исаиа 51:6 (мөн Мозая 16:9; Алма 34:10-г үз.)

Исаиа 53:2–4 (мөн Алма 7:11–13; Еврей 2:16–18-ыг үз.)

Исаиа 53:8–11 (мөн Мозая 15:10–13-ыг үз.)

Унших нэмэлт материал: Мозая 14–15

“Майхныхаа талбайг өргөтгө”

Исаиа 54–56; 63–65-ыг судал.

- Исаиа Сүмийг майхантай, Сүмийн гадасыг майхны гадсуудтай зүйрлүүлсэн байдаг (Исаиа 54:2). Сүм болон гадастай холбоотой ямар зөвлөгөөнүүдийг тэр өгсөн бэ? (Исаиа 54:2–3-г үз.) Өөрсдийн амьдарч буй гадаснуудаа хүчтэй болгохын тулд бид юу хийж чадах вэ?

- Үр тариаг бороо ба цасны ус гэжээдэгтэй адилаар бидний бодгалийг Бурханы үг гэжээж чадна хэмээн Исаиа бичсэн байдаг (Исаиа 55:10–13). Бурханы үг бидний бодгалийг яаж гэжээдэг вэ? (Алма 32:28-г үз.)

- Исаиа 65:17–25-д бичсэнээр Мянган жилд ямар нөхцөл байдал оршин тогтнох вэ?

“Би чамайг өнөөдөр ...төмөр багана болгов”

Иеремиа 1–2; 15; 20; 36–38-г судал.

МЭӨ 626–586 он хүртэл, таван хааны засаглалын хооронд Иеремиа номлолоо хийж байсан (Иошуагаас Зедекиа хүртэл).

- Урьдчилсан томилолтын талаар Иеремиагийн дуудлага юу заадаг вэ? (Иеремиа 1:5-г үз.)
- Их Эзэний дуудлагат номлолыг биелүүлэхдээ Иеремиа ямар эсэргүүцлүүдтэй тулгарсан бэ? (Иеремиа

20:1–6; 26:7–15; 36:1–6, 20–24, 27–32; 37:12–16; 38:4–13-г үз.)

- Бид Иеремиагаас суралцсанаар бэрхшээлтэй тулгарсан үед хэрхэн даван туулж чадах вэ?
- Иеремиа 20:9. Өөрийнхөө дотор байгаа Их Эзэний үгийг Иеремиа хэрхэн тайлбарласан бэ? Их Эзэний үг нь ясаар хаагдан хүрээлэгдсэн шатаж буй гал байна гэдэг нь юу гэсэн утгатай вэ?

Иеремиа 16; 23; 29; 31-ийг судал.

- Иеремиа 31:31–34-д өгүүлснээр Их Эзэн хожмын өдрүүдэд юу хийхээр амласан бэ? (мөн Езекиел 11:17–20; 36:24–28; 2 Коринт 3:2–3-ыг үз.) Бурханы хуулийг зүрхэн дээрээ бичих гэдэг нь ямар утгатай вэ? Зүрхэн дээрээ Бурханы хуулийг бичихийн тулд бид юу хийх ёстой

вэ? Зүрхэн дээрээ Бурханы хуулийг бичсэнээр бидний зан чанарт яаж нөлөөлдөг вэ?

- Иеремиа 29:12–14-д өгүүлснээр Бурхантай ойр байхын тулд бид юу хийж чадах вэ?

Унших нэмэлт материал: Иеремиа 3–9; 13; 30; 32:37–42; 33; 35.

Израилын Хоньчид

Езекиел 18; 34; 37

Дараах судруудыг судал:

- A. Езекиел 34. Их Эзэн сүргээ хооллодоггүй тэдгээр хоньчдыг зэмлэв. Тэрээр бүх төөрсөн хоньдыг олох бөгөөд тэдний Хоньчин нь байх болно.
- B. Езекиел 18:21–32. Езекиел ёсон бус явдалтнууд наманчилвал аврагдах бөгөөд зөв шударгууд ёсон бус явдалтан болвол хөөгдөх болно хэмээн заадаг.
- V. Езекиел 37:1–14. Езекиел үзэгдэл үзэх ба үзэгдэлд нь олон хуурай яснуудад амьдрал олгогддог.
- Г. Езекиел 37:15–28. Езекиел Иудагийн саваа ба Иосефын саваанууд Их Эзэний гарт нэгдэх болно хэмээн бошиглосон.

МЭӨ 597 онд Вавилоны хаан Небухаднеззар Иудагийн хаант улсаас олон хүмүүсийг олзолдог. Эдгээр хүмүүсийн дотор Езекиел байсан ба Их Эзэн таван жилийн дараа түүнийг бошиглогчоор дууддаг. Езекиел МЭӨ 570 он хүртэл цөллөгдсөн хүмүүст номлол айлдаж байв.

Езекиелийн бичсэн зүйлд зөвхөн эртний Иудагийн хаант улсад хамаатай бус бүх Израил болон өнөөдрийн Сүмийн гишүүдэд ч хамаатай сануулга амлалтууд багтдаг. Иерусалим устгагдсан хэдий ч Езекиел Израилын дахин цугларалт ба сэргээлтийг урьдчилан харсан ажээ.

- Езекиел 34-д яригдаж буй “Израилын хоньчид” гэж хэн бэ? Бид ямар утгаараа бүгд Израилын хоньчид бэ?
- Аврагч яагаад бидний хоньчин бэ? (Езекиел 34:11–16; Дуулал 23-г үз.)
- “Шинэ зүрх ба шинэ сүнстэй ...болох” гэдэг нь ямар утгатай вэ? (Езекиел 18:31). Бид энэхүү зүрхний өөрчлөлтийг хэрхэн мэдэрч чадах вэ? (Алма 5:7–14-г үз.)
- Езекиел 37:15–28 –д тэмдэглэгдсэн бошиглолд Иудагийн саваагаар төлөөлүүлсэн зүйлсийн нэг нь Библи юм. Иосефын саваагаар төлөөлүүлсэн зүйлсийн нэг нь Мормоны Ном юм. Библиэс гадна Мормоны Номыг хүлээн авснаар ямар адислалуудыг авчирсан бэ?

Унших нэмэлт материал: Езекиел 2.

“Гол урсах газар бүрд үржин тархагч амьд амьтан амьдрах болно”

44

Езекиел 43–44; 47

Дараах судруудыг судал:

- A. Езекиел 43:1–12; 44:6–9, 23.
Езекиелд Иерусалим дах ариун сүмийн тухай үзэгдлийг үзүүлэв.
- B. Езекиел 47:1, 6–12. Езекиел гол ариун сүмээс урсан гарч цөлд амьдрал өгөн Сөнөсөн Тэнгисийг эдгээхийг үзэв.
- V. Езекиел 47:2–5. Езекиел голын гүнийг хэмжин үзээд голын ус түүнийг гатлах бүрт улам гүнзгий болж байгааг мэдэв.
- Езекиел 43:1–12 ба 44:6–9, 23-аас ариун сүмийн талаар та нар юуг суралцсан бэ?

- Езекиелийн үзэгдэлд ариун сүмээс гол урсан гарч ингэснээр Иерусалимийн зүүн хэсэгт орших Иудейн тал ба Сөнөсөн Тэнгист ямар өөрчлөлтүүд гарах вэ? (Езекиел 47:6–12-г үз.) Ариун сүмд байдаг амьдралын ус нь гэрлэлт, гэр бүлүүд, бидний өвөг дээдэст болон Сүмд хэрхэн эдгэрэлт, амьдралыг өгдөг вэ?

Езекиел 47:1, 6–12-ийг судалснаар магадгүй Илчлэлт 22:1–3 ба 1 Нифай 8:10–11; 11:25-ыг судлахыг хүсэж болно. Эдгээр эшлэлүүдэд ижил төсөөтэй дүрслэлүүд байгааг анхаарна уу.

“Хэрэв би үхэх бол үхнэ”

Даниел 1; 3; 6; Естер 3–5; 7–8

45

Дараах судруудыг судал:

- A. Даниел 1. Даниел болон түүний нөхөд Небухаднезар хааны хоолыг идэхээс татгалзав (1:1–16). Их Эзэн Даниел болон түүний нөхдийг эрүүл мэнд, мэргэн ухаанаар адислав (1:17–21).
- B. Даниел 3. Шадрах, Мешах, Абеде-него нар Небухаднезар хааны шүтээнийг шүтэхээс татгалзав (3:1–12). Небухаднезар хаан тэднийг галт зууханд хийх бөгөөд Их Эзэн тэднийг үхлээс авардаг (3:13–30).
- V. Даниел 6. Дари хааны хүмүүс хааныг гучин өдрийн туршид Бурхан эсвэл өөр нэгэн хүн уруу очиж айлтгал өргөх ёсгүй, зөвхөн түүн дээр ирэх ёстой гэдэг зарлигт гарын үсэг зурахыг ятгадаг (6:1–9). Хааны зарлигийг үл тоон Даниел

Бурханд залбирдаг (6:10–13). Зарлигийг дуулгавартай дагаагүйнх нь шийтгэл болгож Даниелыг арслангийн үүрэнд хаядаг (6:14–17). Их Эзэн тэнгэр элчийг илгээн Даниелыг хамгаалдаг (6:18–23).

- G. Естер 3–5; 7–8. Естерийн хамаатан Мордехай Хаманд хүндэтгэл үзүүлэн бөхийхөөс татгалздаг (3:1–4). Хаан Ахашверошийг хаант улс дах бүх иудейчүүдийг алуулах зарлигийг бэлтгэхийг Хаман ятгадаг (3:5–14). Естер Хаманы түүний хүмүүсийг алах төлөвлөгөөг олж мэдээд өөрийн амьдралаар дэнчин тавин Хаан Ахашверошиос тусламж гуйхаар болдог (4:1–17). Хаан, Хамантай хамт Естерийн гуйлтаар дайлаганд ирэхийг зөвшөөрнө (5:1–8). Дайлаган дээр Естер Хаманы иудейчүүдийг алах гэсэн хуйвалдааныг илчилдэг (7:1–6). Хаан

Хаманыг дүүжлэн алдаг (7:7–10).
Хаан Мордехаид хүндэтгэл үзүүлдэг
ба Естерийн хүсэлтээр Хаманы зар-
лигийг буцаадаг (8:1–17).

Даниел залуу хөвгүүн байхдаа
Иерусалимаас Вавилонд олзлогдон
очдог. Тэр болон бусад өсөх ирээдүй-
тэй Еврей залуус Даниелын найзууд
болох Шадрах, Мешах, Абед-него нар
бөгөөд тэд Небухаднезар хааны тал-
байд бэлтгэгдэв.

Иудей эмэгтэй Естер Даниелын дараа-
гийн үед амьдарч байв. Эцэг эх нь
нас барсны дараа түүнийг хамаатан
Мордехаи өсгөдөг. Естер маш үзэсгэ-
лэнтэй байсан бөгөөд Перис болон
Медийн хаан Ахашверош түүний үзэс-
гэлэн гоог гайхан биширч өөрийн хат-
наа болгов.

- Хаан мах, дарс өгөхөд Даниел болон
түүний нөхөд ямар хариулт өгсөн

бэ? (Даниел 1:8–14-г үз.) Тэдний
хүлээн авсан адислалууд нь Их
Эзэний Мэргэн Ухааны Үгийг дуул-
гавартай дагасан үед бидэнд амлагд-
сан амлалтуудтай хэр төсөөтэй вэ?
(Даниел 1:15, 17, 20; С ба Г 89:18–20)

- Шадрах, Мешах, Абед-него нарыг
зууханд хийсний дараа юу болсон
бэ? (Даниел 3:21–27-г үз.) Зууханд
тэдэнтэй хамт хэн байсан бэ?
(Даниел 3:25-г үз.) Бидэнд хүнд
хэцүү цаг тулгарахад Аврагчид
хандвал бидэнд яаж туслах вэ?
- Өнөөдөр бид Естер шиг зоригтой
байхын тулд ямар бэрхшээлүүдтэй
тулгарах вэ? Үр дагавар нь хэцүү
бэрх байсан ч зөв шударга зүйл-
сийг хийвэл бид ямар адислалуудыг
авах вэ?

Унших нэмэлт материал: Естер 1–2; 6;
9–10.

“Хаанчлал, хэзээ ч устахгүй”

Даниел 2

Дараах судруудыг судал:

А. Даниел 2:1–23. Хаан Небухаднезар
нэг зүүд зүүдэлдэг бөгөөд уг зүү-
дийгтайлахыг зөвлөхүүддээ тушаа-
даг (2:1–13). Даниел найзуудтайгаа
залбирахад зүүд болон түүний
тайллыг Бурхан түүнд илчилдэг
(2:14–23).

Б. Даниел 2:24–49. Даниел хаан
Небухаднезарын зүүдний тайлал
болох дэлхий дээрх агуу хаант
улсуудын сэргэлт ба уналтгүйнчлэн
бусад бүх хаант улсуудаас дээгүүр
Бурханы хаант улсын хожмын
үеийн ялалт зэргийг зөгнөн хэлдэг.

- Хааны зүүдэндээ үзсэн агуу зүйл-
сийг Даниел хэрхэн тайлбарласан

бэ? (Даниел 2:31–33-ыг үз.)
Дүрслэлийн хэсгүүд нь юу юуг
төлөөлүүлдэг вэ? (Даниел 2:36–43-
г үз.)

- “Гар хүрэлгүйгээр ... нэгэн чулуу
цавчигдан” гэдэг нь юуг төлөөлж
байна вэ? (Даниел 2:44–45; С ба Г
65:2-г үз.) Хожмын үеийн Сүмийн
талаар Даниел юу бошиггосон бэ?
(Даниел 2:34–35, 44-г үз.) Даниелын
бошиггосон Сүм нь “бүх дэлхийг
бүрхэх” ба “хэзээ ч устгагдахгүй”
гэдэг нь өнөөдөр хэрхэн биелж
байна вэ?

Унших нэмэлт материал: Сургаал ба
Гэрээ 65

Езра 1–8; Нехемиа 1–2; 4; 6; 8

Дараах судруудыг залбирч судал:

А. Езра 1–6. Хаан Сирус Вавилонд олзонд байсан иудейчүүдийг чөлөөлдөг ба тэднийг Иерусалимд хүрэлцэн ирж ариун сүмийг дахин барихыг урьдаг (Езра 1). Зеруббабел Иешуа хоёр ойролцоогоор 50000 хүнийг Иерусалим уруу удирдан буцаадаг ба тэд ариун сүмийг дахин барьдаг (Езра 2–3). Самаричууд ариун сүм барих ажилд туслахыг санал болгодог ч тэднийг эсэргүүцсэнд барилгын ажлыг зогсоохыг оролддог (Езра 4). Хэдэн жилийн дараа Хаггаи болон Зехариа нарын бошиглогчид иудейчүүдийг ариун сүмийг барьж дуусгахыг уриалах ба самаричууд мөн л эсэргүүцсэн хэвээр байдаг (Езра 5; мөн Хаггаи 1-ийг үз.). Дари хаан ариун сүмийг дахин барих тухай Сирусын зарлигийг шинэчлэх бөгөөд ойролцоогоор МЭӨ 515 онд баригдаж дуусан онцгойлон адислагддаг (Езра 6).

Б. Езра 7–8. Езра Персийн хаан Артаксерксээс иудейчүүдийн өөр нэгэн бүлгийг Иерусалимд удирдан аваачих зөвшөөрлийг авдаг. Езра болон түүний хүмүүс Их Эзэнээс тэднийг хамгаалахыг хүсэн мацаг барин залбирдаг.

В. Нехемиа 1–2; 4; 6. Иерусалимд буцан очсон иудейчүүд “маш хүнд зовлон зүдгүүр ба хараал зүхлэнд орсныг” олж мэдээд Нехемиа хаан Артаксерксээс Иерусалимд очин хотын хэрмийг дахин барих зөвшөөрлийг хүлээн авдаг (Нехемиа 1–2). Иудейчүүдийн дайснууд хэрмийг дахин бариулахгүй байх саадыг хайдаг. Нехемиа хэрмийг барьж дуустал ажлыг амжилттай үргэлжлүүлдэг (Нехемиа 4; 6).

Г. Нехемиа 8. Иерусалимийн эргэн тойронд хэрэм баригдсаны дараа Езра судраас хүмүүст уншиж өгдөг.

Хүмүүс уйлан хуулийн үгсийг дуулгавартайгаар дагахыг хүсдэг.

МЭӨ 562 онд Небухаднезар нас бардаг ба Вавилоны эрч хүч хурдан сулардаг. МЭӨ 539 онд Сирусын удирдлаган доор нэгдсэн Меде болон Персүүдэд Вавилон унадаг. (Даниел 5-ыг үз). Сирус нь сайн санаат удирдагч байсан ба олзлогдсон хүмүүстэйгээ найрсаг харьцдаг, тэдний шашин шүтлэгүүдийг хүндэтгэн үздэг байв.

Сирус Вавилоныг эзэлсний дараа иудейчүүдийг (израилчууд) өөрийн хаант улс буюу Иерусалимд ирж ариун сүмийг дахин барихыг урив.

МЭӨ 458 онд иудей хүн прист ба бичээч Езра өөр нэг бүлэг иудейчүүдийг Вавилоноос Иерусалимд буцаан авчрав. Иудей хүн Нехемиа Вавилоны хааны үйлчилгээний чухал албан тушаалтан болох сөнч бөгөөд тэрээр Иерусалимын хэрмийг дахин барих хааны бүрэн эрх мэдлийг авсан байдаг. Нехемиа, Езра хоёр иудейчүүдэд энэ даалгаврыг биелүүлэхэд нь тусалдаг.

- Санбаллат Нехемиаг ажлаас зогсоон түүнтэй уулзахыг хүсэхэд тэрээр юу гэж хариулсан бэ? (Нехемиа 6:1–4-г үз.) Өнөө үед зарим хүмүүс Сүмийн гишүүдийг Их Эзэний ажлаас хэрхэн сатааруулдаг вэ? Ийм үед бид ямар хариулт өгөх ёстой вэ?
- Езра хэр удаан судруудыг хүмүүст уншиж өгсөн бэ? (Нехемиа 8:3, 17–18-г үз.) Хүмүүс яаж хариулж байсан бэ? (Нехемиа 8:3, 6, 9, 12-г үз.) Судруудыг бид хэрхэн илүү анхааралтай уншиж чадах вэ? Судруудыг уншихдаа эдгээр хүмүүст байсан шиг баяр хөөрийг бид хэрхэн олж чадах вэ?

Унших нэмэлт материал: Хаггаи 1; “Езра” Иосеф Смит Библийн орчуулга, 69-р хуудас; “Нехемиа” Иосеф Смит Библийн орчуулга, 140-р хуудас;

Зехариа 10–14; Малахи

Зехариа 10–14 ба Малахиг судал.

- Зехариа Малахи хоёр эцсийн өдрүүдийн олон үйл явдлуудыг бошиглон хэлсэн байдаг. Доорх эшлэлүүдэд ямар үйл явдлуудыг дүрсэлсэн байдаг вэ?

Зехариа 12:2–3, 8–9

Зехариа 14:3–4 (мөн С ба Г 45:48-ыг үз)

Зехариа 12:10; 13:6 (мөн С ба Г 45:51–53-ыг үз)

Зехариа 14:5 (мөн С ба Г 88:96–98-ыг үз)

Зехариа 14:9

Зехариа 14:12–13; Малахи 4:1–3 (мөн 1 Нифай 22:15–17, 19-ийг үз.)

Малахи 3:1

Малахи 4:5–6 (мөн С ба Г 2; 110:13–16-г үз)

- Малахи хүмүүст аравны нэг болон өргөлөө төлөхгүй бол тэд “Бурханыг луйвардаж” байна гэжээ. (Малахи 3:8–9). Яагаад энэ үнэн бэ?
- “Эцгүүдийн зүрх сэтгэлийг хүүхдүүд уруу эргүүлэх ба хүүхдүүдийн зүрх сэтгэлийг эцгүүд уруу нь эргүүлэх” гэдэг нь юу гэсэн үг вэ? (Энэ нь өөрсдийн өвөг дээдэстэй — “эцгүүдтэй” — бидний бүх хойч үетэй — бидний “хүүхдүүдтэй” — амьд буй болон нас барсан хүмүүстэй санваарын холболтын эрх мэдлээр ба ариун сүмийн ёслолуудаар үүрд мөнхөд холболт хийлгэх юм.)
- Гэр бүлийн түүх ба ариун сүмийн ажлыг өвөг дээдсийнхээ төлөө хийж байхдаа зүрх сэтгэлээ тэдний төлөө эргэхийг чи хэрхэн мэдэрсэн бэ? Ариун сүмийн ёслолын амлалтууд нь та нарын зүрх сэтгэлийг эцэг эх, гэр бүлийн хүн болон хүүхдүүд уруу чинь хэрхэн эргүүлдэг вэ?

Унших нэмэлт материал: Сургаал ба Гэрээ 45.

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

Нүүр: *Ханна хүү Самуэлыгаа Елид өгч байгаа нь*, Роберт Т. Барретт Есүс
Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс хэвлэв

Солт Лейк хот, Юта

© 1996, 2001 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан. АНУ-д хэвлэв
Англи эхийн зөвшөөрөл: 1/01. Орчуулгын зөвшөөрөл: 1/01.

Old Testament: Class Member Study Guide-ын орчуулга

MONGOLIAN



4 02345 92363 9

34592 363